


ТАЙЛАН 2015/2016



Independence

Quality

Impact

Хараат бус Судалгааны хүрээлэн IRIM

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар 14201, Сүхбаатар дүүрэг
8-р хороо, Бага тойруу, 45-30 тоот

Шуудангийн
хайрцаг

46А/265 Улаанбаатар, Монгол

Вэб сайт:

www.irim.mn

Фэйсбүүк хуудас:

IRIMongolia

Утас:

+976-7011-7101

IRIM-ийн тухай	3
Өмнөх үг	4
IRIM хүний нөөц	5
IRIM тоогоор	6
2015 оны онцлох үйл явдал	7
Хэрэгжүүлсэн төслүүд	11
Хэрэгжүүлж буй төслүүд	82

ЭРХЭМ ЗОРИЛГО

Шинжлэх ухааны нарийн судалгаа, шинжилгээнд тулгуурлан үйлчлүүлэгчдээ дэлхийн жишигт нийцсэн хараат бус, үнэн бодит, найдвартай мэдээллээр хангаснаар бүс нутгийн судалгааны зах зээлд мэргэжлийн өндөр стандарт бий болгож нийгмийн судалгааны чиглэлийн тэргүүлэх төв болно.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Судалгаа: Бид найдвартай арга зүйд үндэслэн тоон ба чанарын судалгааны төсл боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Олон мянган оролцогчдоос, сэдэвчилсэн олон асуудлаар найдвартай мэдээлэл цуглуулж, мэдээлэлд нарийвчилсан шинжилгээ хийдэг.

Хяналт үнэлгээ: Төслүүдэд хөндлөнгийн байр сууринаас, үнэн бодитой үнэлгээ өгдөг. Хяналт үнэлгээний ажилд тохирох нөөцийг тогтоож, төлөвлөгөө ба биелэлтийн зөрүүг судлаж, үр дүн, нөлөөг үнэлснээр төслийн үр дүн, сургалтууд зохион байгуулж байна.

Сургалт: Бид иргэд олон нийт, төрийн алба, хувийн байгууллага хувь хүмүүст оролцооны янз бүрийн аргаар сургалтууд зохион байгуулж болно.

Нөлөөлөл: Бид судалгаанд тулгуурлан төрөл бүрийн чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Энэ нь төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх, тухайн асуудалд олон нийтийн зүгээс өгөх ач холбогдол, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой.

Төслийн менежмент: Бид аливаа төслийг эхлүүлэхээс дуусах хүртэл бүхий л үе шатны менежментийг хэрэгжүүлж ажилладаг.

ХАМРАХ СЭДЭВ:

- Засаглал
- Нийгмийн эрүүл мэнд
- Уул уурхай, байгаль орчин
- Боловсрол
- Хөдөөгийн ба хотын өрхүүд
- Эдийн засаг

ӨМНӨХ ҮГ



Онц бөгөөд бүрэн эрхэт
элчин сайд, ИРИМ-ийн
Ерөнхийлөгч
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал
А.Долгион

Бид та бүхэнд IRIM судалгааны хүрээлэнгийнхээ 2015 онд хэрэгжүүлсэн төслүүдийн гол үйл ажиллагаа, хураангуйг толилуулж буйдаа баяртай байна.

2015 он бол дэлхийн улс орнууд Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрөө дэвшүүлж, ирэх 15 жилд хүрэх зорилго, зорилтуудаа тодорхойлсон түүхэн он байлаа. Дэлхийн болон үндэсний хөгжлийн зорилгод хүрэхэд хувийн хэвшил, иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг Тогтвортой Хөгжлийн Зорилгууд чухалчилдаг.

IRIM хүрээлэн өөрийн хэрэгжүүлж буй төслийн менежмент, зөвлөх үйлчилгээгээр дамжуулан эдгээр зорилгод хүрэхэд хувь нэмрээ оруулж байна. 2015 онд бид ил тод, хариуцлагатай байдлыг дэмжиж, авилгаас сэргийлэх замаар төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, дээд боловсролын байгууллагуудын хөдөлмөрийн зах зээл дэх нийцлийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг тодорхойлох, уул уурхайн салбарын бодлого болон бичил уурхайн үр нөлөөг үнэлэх гэх мэт олон төсөл хэрэгжүүллээ.

Бид бас улс, аймаг, сумын түвшний 20 гаруй хурал, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хамтрагчдынхаа итгэлийг хүлээж, хөгжлийн чухал асуудлуудыг хөндсөн олон талын оролцоотой ариа, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг бидний бие даасан, хараат бус үйл ажиллагаа олгодог юм. Тухайлбал, бид өнгөрсөн жилд уул уурхайн компаниуд, орон нутгийн захиргаа, нутгийн иргэдийн хооронд усны менежмент ба орон нутгийн хөгжлийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Бодлого тодорхойлж, шийдвэр

гаргах нэг суурь нь ийм хэлэлцүүлгүүд байдаг.

Түүнчлэн, бид үндэсний хэмжээний Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулах санаачилга гаргаж байна. 2015 онд бид анх удаа зохион байгуулсан Оны хүлээн авалтын үеэр Монголын “Үндэсний Үнэлгээний Хүрээ” санаачилгыг эхлүүлэв. Хөгжлийн төлөө хамтран ажиллаж буй олон улсын ба төрийн байгууллагын төлөөллүүд, экспертүүд үүнд оролцсон юм. Энэ санаачилгын хүрээнд бид Үндэсний Үнэлгээний Чадавхийн Дэлхийн Чуулганд оролцож, “Дэлхийн Үнэлгээний Хөтөлбөр 2016-2020”-ийг боловсруулахад хувь нэмрээ орууллаа.

Чанартай судалгааны бүтээгдэхүүн, зөвлөх үйлчилгээг хүргэхийн тулд үнэлгээ, сайжруулалт тасралтгүй хийгддэг менежментийн тогтолцоо онцгой чухал билээ. Иймээс IRIM хүрээлэн 2016 онд ISO 9001 чанарын удирдлагын гэрчилгээ авах зорилт дэвшүүлж байна. Ингэснээр бид олон улсын ISO 9001 стандарт шаардлагыг хангасан Монголын анхны зөвлөх үйлчилгээ, судалгааны байгууллага болох юм.

Бидний үйл ажиллагаа, түншлэлд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулж буй зөвлөхүүддээ, харилцагчиддаа талархал илэрхийлье.

Энэхүү тайлан нь Монголд хэрэгжиж буй зарим томоохон судалгааны төслийн талаар мэдээлэл түгээх зорилготой тул тайланг маань тогтож уншихыг хүсье.

Ирэх жилд манай үндсэн баг, зөвлөхүүд, түншүүд, харилцагчид хамтдаа чанартай үйлчилгээг чигч шударгаар хүргэхийн төлөө үргэлжлүүлэн хамтарч ажиллана гэдэгт итгэл төгс байна.

IRIM ХҮНИЙ НӨӨЦ

— МАНАЙ СУДЛААЧИД —



Манай байгууллага судалгаа, сургалт, төсөл удирдан зохион байгуулах болон зөвлөх үйлчилгээний өндөр мэдлэг туршлагатай 28 тогтмол ажилтантай. Манай ажилчид социологи, нийгмийн ажил, нийгмийн эрүүл мэнд, улс төр, сэтгэл зүй, эдийн засаг, хууль эрх зүй, менежментийн чиглэлээр мэргэшсэн бөгөөд нийгмийн судалгааны чиглэлээр гурваас хорин жилийн ажлын туршлагатай мэргэжилтнүүдийг эгнээндээ нэгтгэсэн.

Зөвлөхүүдийн баг: Байгууллага нь шаардлагатай үед зохих үйл ажиллагаа, арга зүйг хэрэгжүүлэхэд олон улсын хэмжээнд ажилласан туршлагатай үндэсний болон гадаадын мэргэжилтэн, зөвлөхүүдийн багийг ажиллуулдаг. Тэд байгууллагад шаардлагатай гүнзгий мэдлэг туршлага, төсөл хэрэгжүүлэхэд чухалд тооцогдох инновацийг нэвтрүүлж байна. Тэд төслийн удирдагч, багийн ахлагч нарт шууд харицан тайлагнаж ажилладаг ба аливаа төсөл, арга хэмжээнд бодитой үр дүнг авчирдгаараа онцлог юм.

Туслах баг: Төслийн туслах ажилтнуудын дийлэнх нь IRIM-ийн хэрэгжүүлж буй төслүүд дээр гэрээлэн ажилладаг ба гэрээт ажлын онцлогоос хамааран тогтмол болон тодорхой хуваарийн дагуу ажиллаж байна. Манай байгууллага харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар бүхий олон гэрээт судлаачдыг багийг бүрдүүлсэн байна. Бид ямар ч үед судалгаа шинжилгээний төсөл дээр дэмжлэг үзүүлж ажиллах 30 орчим гэрээт судлаачидтай.

IRIM ТООГООР

НИЙТ
121
ТӨСӨЛ



2008 ОНЫ
4 Саргаас

2015 ОНЫ
12 сар

49

Засаглал

21

Эдийн засаг

18

Боловсрол

11

Нийгмийн эрүүл мэнд

10

Хөдөөгийн өрх

14

Уул уурхай, байгаль орчин

112495
Респондент



73 Захиалагч





135 Хамтрагч

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Улаанбаатар	93	Хөвсгөл	21	Орхон	17
Ховд	35	Архангай	19	Увс	24
Дорноговь	26	Сүхбаатар	18	Говьсүмбэр	15
Өмнөговь	26	Төв	19	Дундговь	18
Дархан-Уул	25	Хэнтий	21	Сэлэнгэ	22
Өвөрхангай	24	Баян-Өлгий	16	Булган	12
Баянхонгор	24	Дорнод	21	БНХАУ Эрээн хот	1
Говь-Алтай	24	Завхан	18		

Дэлгэрэнгүй тус 539



Бидний ёс зүйн болон мэргэжлийн зарчим



Олон улсын социологийн холбоо (ISA)-ийн гишүүний хувьд бид тус холбооны Гүйцэтгэх зөвлөлөөс баталсан Ёс зүйн дүрмийг хатуу баримтлан ажилладаг.



Манай хүрээлэнд Нийгмийн хариуцлагын Азийн сүлжээний Гүйцэтгэх хорооны гишүүн байгууллага. Иймээс бид нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг дэмжин ажиллахыг зорьдог.



2015 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛЯВДАЛ

АХБ-ны "Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь" техник туслалцааны зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжиж эхлэв.


Жилийн тайлан-2014 хэвлэгдэн гарлаа.
ИРИМ үүсгэн байгуулагдсаны 7 жилийн ой боллоо.
Манай байгууллага Gabriel Al-Salem сангаас зохион байгуулдаг Олон улсын шилдэг зөвлөхүүдийг шалгаруулах наадамд амжилттай оролцож "Consulting Without Borders" гэрчилгээг гардан авлаа.

ИРИМ судалгааны хүрээлэн ХЭҮСМҮТ-ийн захиалгаар "Хөдөлмөр эрхлэлтийн барометр-2015» судалгааг улс орон даяар зохион байгууллаа.

Гүйцэтгэх захирал А.Долгион Бангкокийн 2016-2020 оны "Үнэлгээний үндэсний чадавхи болон Олон улсын үнэлгээний хөтөлбөр"-ийн тунхаглалд оролцлоо.

Дэлхийн банкны захиалгаар Орон нутгийн хөгжлийн загвар гэрээний хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав.

Гүйцэтгэх захирал А.Долгион байгууллагынхаа үйл ажиллагаа, монгол дахь үнэлгээний тогтолцооны талаар defacto нэвтрүүлэгт оролцон ярилцлага өгөв. Төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдал төсөл-Төрийн байгууллын вэб сайт дах мониторинг-3 хийгдэж дуусав. ИРИМ судалгааны хүрээлэн жил бүрийн Хүлээн авалтыг Элчин сайд, ИРИМ-ийн Ерөнхийлөгч ноён Х.Бэхбатын ивээл дор зохион байгуулав. PDAC-2016 Хайгуулчид болон хөгжүүлэгчдийн холбооны 84 жилийн ойн үйл ажиллагаанд Ч.Тамир зөвлөх оролцов.



Гүйцэтгэх захирал А.Долгион Лондон хотод 3ie-ийн зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцов.

"Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хийх үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшүүлэх" сургалт зохион байгуулагдав.

АНУ-дах Монгол судлалын хуралд ИРИМ-аас З.Манлайбаатар, Н.Минжирмаа нар, МИРИМ-ээс Н. Янжинпагма нар оролцож илтгэл тавьлаа.

ОУСК-ийн захиалгаар Өмнөговийн бүс нутгийн усны менежментийг сайжруулах зорилго бүхий олон талын оролцоот хэлэлцүүлгийг Өмнөговь аймгийн 15 сумдад зохион байгууллаа.

Ч.Тамир зөвлөх Бангладеш-д Авилгын эсрэг байгууллагын үнэлгээний багийн гишүүдийг чадавхжуулах семнарт оролцов.
ИРИМ Их 7 орны хурдацтай хамтын ажиллагааны чуулга уулзалтад МОҮИТБС-ын нөлөөллийн үнэлгээний талаарх загварыг танилцууллаа.
"Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 ба Үндэсний үнэлгээний тогтолцоо" эсдэвт хуралд оролцлоо.
"Үндэсний хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд газар, загас, ойн нөөцийн эдэлбэрийн хариуцлагатай засаглалын сайн дурын зөвлөмжийг хэрэгжүүлэх" үндэсний 2-р семинарт ИРИМ-аас төлөөлөн оролцов.

IRIM БАНГКОКИЙН 2016-2020 ОНЫ “ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ЧАДАВХИ БОЛОН ОЛОН УЛСЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ТУНХАГЛАЛД ОРОЛЦЛОО.



IRIM 10-р сарын 26-30 хооронд Тайландын Бангкок хотод “Үнэлгээний үндэсний чадавхи”-ийн (NEC) олон улсын 4-р бага хуралд оролцлоо. Уг хурал нь “Иргэдийн амьдралыг өөрчлөх хөгжлийн туршлагын үнэлгээний холимог зарчим” сэдвийн дор явагдлаа. Бага хурлын үеэр 100 орны 400 орчим төлөөлөгчид ирсэн бөгөөд засгийн газар, парламент, хөгжлийн байгууллагууд, олон талт болон 2 талт байгууллагууд, мэрэгжлийн үнэлгээний байгууллагуудаас мөн төлөөллүүд иржээ.

Оролцогчид болон үнэлгээний нийгэмлэг хоорондоо олон талын туршлагаа хуваалцаж тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих үнэлгээ практик сорилт, боломжийн талаар нийтлэг ойлголтод хүрсэн. Бага хурлын төгсгөлд “Тогтвортой хөгжлийн зорилтуудын үндэсний үнэлгээний чадавхийн Бангкокийн тунхаглалыг оролцогчид баталсан байна.

IRIM ИХ 7 ОРНЫ ХУРДАЦТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧУУЛГА УУЛЗАЛТАД МОУИТБС-ЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЗАГВАРЫГ ТАНИЛЦУУЛСАН.



“Их 7 орны хурдацтай хамтын ажиллагааны чуулга” Улаанбаатар дахь Шангри Ла зочид буудалд зохион байгуулсан. Камбож, Мьянмар, Лаос, Вьетнам 4 улсын төлөөлөгчид 2 өдрийн туршид туршлагаа хуваалцсан юм.

IRIM нь IMRI хөтөлбөрт харилцан ойлголцлын санамж бичиг боловсруулах семинарыг зохион байгуулахад арга зүйн зөвлөгөө үзүүлэхийн зэрэгцээ эцсийн харилцан ойлголцлын санамж бичгийг эцсийн хувилбарыг боловсруулахад туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн IRIM “МОУИТБС үр нөлөөг хэмжих” онолын өөрчлөлтийн загварыг танилцуулсан. Танилцуулга нь Камбож, Бирм, Лаос, Вьетнамын төлөөлөгчидийн сонирхлыг маш их татсан.

2015 оны 11-р сарын 10, 11-нд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялагийн санаачилга хөтөлбөрөөс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дунд шатны үнэлгээний хүрээнд



АВИЛГЫН ЭСРЭГ БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СЕМНАР

Үнэлгээний багийн гишүүдийг чадавхжуулах сургалтын талаар мэдээлэл: Транспэрэнси Интернэшнл-ийн үнэлгээний багийн гишүүдийг чадавхжуулах сургалт Бангладеш хотын Дака хотод 2015 оны 11 сарын 10-12 –ны өдрүүдэд зохион амжилттай зохион байгуулагдаж “IRIM” –хүрээлэнгийн үндсэн судлаач Тамир, “TI-Монгол”-ийн хөтөлбөрийн менежер П.Анузаяа нар оролцов. Тус сургалтанд Бангладеш, Шри Ланка, Индонези, Тайван, Монгол зэрэг 6 улс орны оролцогчид оролцож АТГ-ын үнэлгээний ажлын зорилго, зорилт хийгдэх үйл ажиллагаа бүхий ерөнхий танилцуулга, хяналт-үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, тэдний үнэлэх оноо, мэдээллийг цуглуулах арга, аргачлал, Бутан улсад хийгдсэн судалгааны сургамж, ач холбогдол болон АТГ-ын үнэлгээний тайлан гаргах үндсэн загварын талаар ярилцлага, лекц зохион явагдсан.



МОНГОЛ СУДЛАЛЫН 9 ДҮГЭЭР БАГА ХУРАЛ

АНУ-гийн Соёлын Төвөөс, Монгол улсын ЭСЯ-тай хамтран зохион байгуулдаг Олон улсын Монгол судлалын 9 дүгээр бага хуралд АНУ-ийн Вашингтон хотод болсон. Үг хуралд IRIM Судалгааны хүрээлэнг төлөөлөн Дэд захирал З.Манлайбаатар, судлаач Н.Минжирмаа, МИРИМ ХХК-ийн судалгааны менежер Н.Янжинпагма нар илтгэл тавин оролцсон.



PDAC-2016 ХАЙГУУЛЧИД БОЛОН ХӨГЖҮҮЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ 84 ЖИЛИЙН ОЙ

PDAC олон улсын конвенц нь хувь хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд болон ашигт малтмалын хайгуулчид хоорондоо холбоо тогтоох дэлхийд тэргүүлэх үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалтын конвенц юм. Канадын Торонто хотод 1932 оноос хойш жил бүр 4 өдөр явагддаг уг конвенцийн хамрах хүрээ, нэр хүнд, нөлөөлөл нь өсч байгаа бөгөөд өнөөдөр дэлхийн ашигт малтмалын салбарын нэн чухал үйл явдал болсон байна. 100 гаруй орны 1000 гаруй зохион байгуулагчид, 25122 оролцогчдод техникийн уулзалт, богино сургалтууд болон нийгмийн сүлжээний үйл явдалд оролцох боломжийг олгодог. Манай байгууллага ТУЗ-ийн дарга ноён Ч.Тамир уг хуралд оролцлоо.

2015 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛЯВДАЛ



ИРИМ Судалгааны хүрээлэн нь үүсгэн байгуулагдсан цагаасаа үнэлгээний бодлого, хэрэглээг идэвхжүүлэх талаар олон улсын санаачлагыг дэмжиж, үндэсний төрийн бодлого, хөтөлбөрт тэдгээрийг тусгахад дэмжлэг үзүүлэх чиглэлд эрчимтэй оролцсоор ирсэн.

Энэ хүрээнд ИРИМ судалгааны хүрээлэн 2015 оны 12 дугаар сарын 4-ны өдөр Улаанбаатар хотноо байгууллагын нэрэмжит анхны хүлээн авалтаа 'Тогтвортой Хөгжлийн Зорилтууд 2030: Үндэсний үнэлгээний хүрээний үүрэг' сэдвээр зохион байгууллаа.

Арга хэмжээний зорилго нь тухайн сэдвээр оролцогчид харилцан яриа өрнүүлэх индэр болоход чиглэсэн ба судалгааны хүрээлэнгийн зүгээс Монгол улс үр дүнд суурилсан засаглалыг бэхжүүлэх үндэсний бодлого, чадавхийг сайжруулах талаар өөрсдийн санаачлагуудыг танилцуулсан.

Хүлээн авалтыг Доктор Х. Бэхбат (ОББЭЭС, ИРИМ судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч) санаачлан зохион байгуулж, Д. Жаргалсайхан (Дэ Факто) удирдан чиглүүлсэнээр зочдын дунд найрсаг, дулсан уур амьсгал бүрдүүлж хэлэлцүүлгийг үр дүнтэй өрнүүлэхэд дэмжлэг үзүүлсэн юм.

Хүлээн авалтанд 45 гаруй зочид оролцсон нь тухайн сэдвийн ач холбогдлыг харуулсан юм. Хүрэлцэн ирсэн зочид нь Төрийн байгууллагын албан хаагчид, тэр дундаа Сангийн Яамны төлөөлөгчид, Үндэсний Статистикийн Хороо, Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Сан; мөн Швейцарын Хамтын Ажиллагааны Газар, Жайка, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Дэлхийн Зөн, Олон Улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагуудын төлөөлөгчдөөс гадна Япон, Канад, Америк улсын Элчин Сайдын Яамд болон олон улсын, үндэсний хэмжээний мэргэжилтнүүд байлаа.

Арга хэмжээг эхлүүлж Нэгдсэн Үндэсний байгууллагын суурин зохицуулагч хатагтай Бэатэ Транкманн эхний илтгэлийг танилцуулсан. Тэрээр илтгэлдээ Нэгдсэн Үндэсний байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтын талаарх ерөнхий хандлага, түүнд хэрхэн мониторинг хийх талаар дурьдсан бөгөөд хамгийн чухал нь ирээдүйд Монгол улсад Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлэх талаарх өөрийн үзэл бодлоо хуваалцлаа.

Дараагийн танилцуулгыг ИРИМ Судалгааны хүрээлэнгийн захирал хатагтай А. Долгион танилцуулсан. Тэрээр Монгол улс дахь өнөөгийн мэдээлэл болон үнэлгээний алдаа дутагдлыг танилцуулж эдгээр нөхцөл байдлыг сайжруулах боломжыг тодорхойлсон юм.

Хүрэлцэн ирсэн зочдын зүгээс “үнэлгээ нь хяналт, шалгалт хийх гэхээс илүү суралцах арга хэрэгсэл” гэдэг ач холбогдлын талаар сурталчлах хэрэгтэй гэсэн санал гаргасан. Мөн Тогтвортой Хөгжлийн Зорилт нь хувийн хэвшлийн оролцоог маш их дэмжиж байгаа нь Тогтвортой Хөгжлийн Зорилтын үнэлгээг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийг оролцуулах нь зүйтэй гэдгийг тэмдэглэж байв.

Тус арга хэмжээг Нэгдсэн Үндэсний байгууллагаас зарласан “Олон улсын үнэлгээний жил 2015” тунхаглалын хүрээнд Тогтвортой Хөгжлийн Зорилт болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах чухал мөчид цагаа олсон арга хэмжээ боллоо хэмээн оролцогчид дүгнэлээ.

Төгсгөлд нь Жаргалсайхан Үндэсний Үнэлгээний Тогтолцооны санаачлагыг бэхжүүлэх талаар ИРИМ судалгааны хүрээлэнгийн байр суурийг нэгтгэн дүгнэсэн юм. Мөн тэрээр үзэл бодол нэгт хүмүүсийн оролцоо, хамтын ажиллагааны зүтгэлээр дамжуулан Монгол улс нь Олон улсын болон бүс нутгийн хүрээнд Тогтвортой Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэх сайн туршлага болж болохыг онцлон тэмдэглэсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

- Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдалын Санаачилгын Нөлөөллийн Үнэлгээний Аргачлал (ОҮИТБС) **12**
- "Залуучуудын хөгжлийн хөтөлбөр"-ийн суурь судалгаа **15**
- Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжийн төслүүдийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг дээшлүүлэх төсөл **19**
- Тогтвортой бичил уурхай: "Зорилтот бүлгийн дунд мэдлэгийн төв бий болгох" **22**
- Бичил бизнесийг дэмжих замаар ядуурлыг бууруулах төслийн эцсийн үнэлгээ **26**
- Усны талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тодорхойлох судалгааны үр дүнг танилцуулах хэлэлцүүлэг **29**
- Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтын ажиллагааны хөтөлбөр /2013-2016/-ийн мониторингийн судалгаа **32**
- "Хотын засаглал" төслийн суурь судалгаа **36**
- Монгол улсын 1-р ангийн сурагчдыг сургуульд үр дүнтэй бэлтгэх, суралцах таатай орчинг бүрдүүлэхэд сургуулиудыг чадавхижуулах судалгаа **40**
- "Алт, үнэт эдлэлийн зах зээлийн судалгаа" **44**
- Бичил уурхайчдын орон нутагт үзүүлж буй эдийн засгийн үр нөлөө **46**
- Хөдөлмөр эрхлэлтийн барометрийн судалгаа **50**
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны шударга байдал, шийдвэрийн ил тод, нээлттэй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх **53**
- Төрийн байгууллагын вэбсайтын ил тод байдал төсөл-Төрийн байгууллын вэб сайт дах мониторинг-3 **57**
- "Хөдөөгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих" төслийн төгсгөлийн үнэлгээний судалгаа **60**
- Монголын хүнсний ногоо, мал аж ахуй, нэхмэлийн салбарын тэргүүн туршлагын судалгаа **64**
- АТГ-ын эрх зүйн орчин, үйл ажиллагааны үнэлгээ **67**
- Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох судалгаа **70**
- Уул уурхайн лицензийн нээлттэй мэдээллийн санд хийх бодлогын судалгаа **74**
- "Орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээ" үндэсний хэлэлцүүлэг **76**
- Монгол улсад олборлох салбарын менежментийг сайжруулах нь-Хэлэлцүүлэг **79**

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛЫН САНААЧИЛГЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ (ОУИТБС)



Захиалагч: Нөлөөллийн Үнэлгээний Олон Улсын Санаачилга (3ie), Их Британийн Олон Улсын Хөгжлийн Газар

Төслийн танилцуулга:

Байгалийн нөөцийг илрүүлж, олборлодог бага орлоготой орнууд үүнээс бий болох баялгаа ард иргэддээ хүртээж чаддаггүй нь олон судалгаагаар нотлогддог. Гэтэл байгалийн нөөцийн үр шим хувийн компаниудад үлддэг. Эдгээр компани татвараа төлсөн ч ихэнх орлого нь авилгаар дамжин алга болдог. Үүнийг “байгалийн баялгийн парадокс” гэдэг. Монгол улс уул уурхайн баялаг илрүүлж, олборлож эхэлж байгаа улсуудын нэг. Байгалийн нөөцийн олборлолтыг удирдаж, засаглах, “баялгийн хараал”-аас сэргийлэхийн тулд Монгол улс 2006 онд Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгад нэгдэн орсон. Дэлхий нийтийн энэхүү санаачилга нь байгалийн нөөцийн засаглал дахь хувийн хэвшил, төрийн байгууллага, иргэдийн дундах нээлттэй, ил тод байдлыг дэмжих зорилгоор байгуулагдсан. Тус санаачилга нь компаниудыг үйл ажиллагаа болон орлогоо тайлагнах, засгийн газрыг хүлээн авсан татвараа мэдээлэхийг шаарддаг. Мөн компаниуд, засгийн газар, ард иргэдийн хооронд идэвхтэй сайн харилцааг дэмждэг. Ингэснээр:

- Ард иргэд өөрсдийн хүртэх хувиа шаардахад хэрэгтэй мэдээлэлтэй болно.
- Уул уурхайн салбарын хөгжил дээшилнэ.
- Засаглалыг сайжруулна.

Үүний үр дүнд жирийн иргэдийн амьжиргаа дээшилнэ гэж үздэг.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Үнэлгээний багийн дэвшүүлсэн ерөнхий асуултууд:

- Уул уурхайн өртгийн сүлжээн дэх олборлох салбарын ил тод байдал, хариуцлагын тогтолцоонд Монголын ОУИТБС ямар хувь нэмэр оруулж байгаа вэ?
- Олон нийт уул уурхайн салбарын мэдээлэлд нэвтрэх боломж, иргэний нийгмийн байгууллагын ба иргэдийн оролцоо нь тус салбарт итгэх итгэлийг дээшлүүлж, Монголын нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулсан уу?

Дээд түвшний үр нөлөөтэй холбоотой үнэлгээний асуултууд:

1. ОУИТБС-ын үйл ажилгаанууд нь ашигт малтмалын орлогын өсөлт, эдийн засгийн өсөлт, үндэсний орлогыг дээшлүүлэхэд ямар нөлөө үзүүлсэн бэ?
2. ОУИТБС-ын үйл ажилгаанууд нь Монгол дахь ядуурлыг бууруулах, иргэдийн орлогыг дээшлүүлэхэд ямар нөлөө үзүүлсэн бэ? Олборлох салбарын талаар олон нийтийн мэдлэг ойлголт ба итгэл нэмэгдэж байна уу?
3. ОУИТБС-ын үйл ажилгаанууд нь тухайн салбарынхаа үр дүнтэй, үнэн зөв тайлагнах, уул уурхайн салбарын тоглогчдын хариуцлага, тайлагналтын ил тод байдал, орлогын бүрдэл, зарлага зэрэгт ямар нөлөө үзүүлсэн бэ?

Уг санаачилга ядуурлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэхэд ямар үр нөлөө үзүүлснийг

үнэлэхэд цаг хугацааны хувьд хэцүү юм. Тиймээс үнэлгээний ажил нь иргэд ба иргэний нийгмийн оролцоонд илүү төвлөрөх юм.

Үнэлгээний дагалдах асуултууд:

1. Уг хөтөлбөр иргэний нийгмийн байгуулга ба иргэдийн уул уурхайн салбарын засаглал, институт дэх оролцоо дээшилсэн үү? Энэ нь жендэр болон нийгмийн бусад ялгаанаас хэрхэн хамаарах вэ? Иргэд болон иргэний нийгмийн байгууллага хоорондын харилцаа, иргэний нийгмийн байгууллага, иргэд ба төрийн байгууллагуудын хоорондын харилцаа нь үр дүнтэй явагдаж байна уу?
2. Уг хөтөлбөр нь иргэний нийгмийн байгууллага/иргэд ба уул уурхайн компаниудын харилцааг сайжруулсан үү? Энэ нь жендэр болон нийгмийн бусад ялгаанаас хэрхэн хамаарах вэ? Иргэний нийгмийн байгууллага, иргэд ба уул уурхайн компаниудын хоорондын харилцаа үр дүнтэй явагдаж байна уу?
3. Уг хөтөлбөр нь төрийн байгууллага уул уурхайн компаниудын харилцааг дээшлүүлсэн үү? Эдгээр тоглогчдын хоорондын харилцаа үр дүнтэй явагдаж байна уу?
4. Иргэд/иргэний нийгмийн байгууллагууд уул уурхайн салбарын шийдвэр гаргалтад оролцох, нөлөөлөх илүү чадавхитай болсон үү? Энэ нь жендэр болон нийгмийн бусад ялгаанаас хэрхэн хамаарч байна вэ?



2014 оны
12 сараас

2015 оны
4 сар

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Уг үйл ажиллагаа амжилттай болох урьдач нөхцөлүүд (assumptions) ба Өөрчлөлтийн онолыг (Theory of Change) боловсруулсан.

Үнэлгээний аргачлал:

Үнэлгээ нь уул уурхайн компаниуд болон ард иргэдээс асуулга судалгаа авах, хувь нэмрийг шинжлэх кэйс судалгаа зэргийг ашиглана. Мөн Вайт, Филлипс (2012) нарын “Small-n” хэмээх үр нөлөөг үнэлэх аргачлалын Бүлэг-1-д багтах аргуудыг ашиглана. Энэ холимог аргачлал нь янз бүрийн баримтыг ашиглан таамагласан үр дүнг шалгах, шалтгаант холбоо, нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох боломж олгодог. Үндсэндээ, энэхүү шинжилгээ нь Монгол дахь ОУИТБС-ын үйл ажиллагааны хүрээнд “гарч болох хувь нэмэр”-ийг тодорхойлоход чиглэсэн.

Үр нөлөөний үнэлгээний дизайныг боловсруулахдаа бид дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн:

- Тухайн салбарын судлагдсан байдлыг тодруулах зорилгоор судалгааны ажлуудын тойм шинжилгээ хийсэн.
- ИРИМ судалгааны хүрээлэн Монголын Уул Уурхайн яамтай хамтран ОУИТБС-ын Хэрэг эрхлэх газрын тусламжтайгаар Лондонд зохион байгуулагдсан Олборлох салбарын Ил тод байдал, Хариуцлагатай байдлын Санаачилгын хуралдаанд оролцож, судалгааны аргачлалаа танилцуулсан.
- Оролцогч талуудтай зөвлөлдөж, уг үнэлгээ судалгааны ажилд бодлогын түвшинд хэрхэн оролцох төлөвлөгөөг боловсруулсан.

- Бодлого боловсруулагчдын хэрэгцээг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, уг санаачилгыг үндэсний хэмжээнд төдийгүй орон нутгийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх, уул уурхайгаас бусад салбарт хэрхэн хэрэглэж болохыг тодорхойлсон.
- ИРИМ хүрээлэн нь ОУИТБС-ын гишүүн уул уурхайн компаниуд, Татварын ерөнхий газар, иргэний нийгмийн байгууллагуудтай болон ОУИТБС-ын Зөвлөлд багтдаг төрийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, нөхцөл байдлын шинжилгээ хийсэн.
- Үнэлгээний өөрчлөлтийн онол ба аргачлалыг боловсруулсан (үнэлгээний асуултууд, тоо баримт цуглуулах арга, түүвэрлэх стратеги гэх мэт).

Үр нөлөөг үнэлэх энэхүү аргачлалыг ашигласнаар, бодит үнэлгээ хийх боломжтойгоос гадна бодлого тодорхойлогчид дараах асуултуудад хариулах боломжтой юм. Үүнд:

1. Уг төслийг орон нутгийн түвшинд хэрхэн дэлгэрүүлэх вэ?
2. Уул уурхайн салбарын нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн хуралд хэрэгтэй, нутгийн онцлогийг тусгасан мэдээллийг хэрхэн хүргэх вэ?
3. ОУИТБС-ын хуулийн төсөл батлагдсан тохиолдолд хэрэгжилтийг нь хэрхэн хангах вэ?

Энэхүү үнэлгээ нь ОУИТБС ба нийгмийн өөрчлөлтийн холбоог кэйс судалгаа болон үр нөлөөг үнэлэх боловсронгуй аргын тусламжтайгаар нотлон харуулах юм.

‘ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР’-ИЙН СУУРЬ СУДАЛГАА (2013-2017)



Захиалагч: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан (НҮБХАС)


Судалгааны зорилго, зорилт: Энэхүү судалгаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн:

- Төслийн ХШҮ-ний тогтолцоонд заагдсан суурь мэдээллийг цуглуулах;
- Төслийн хэрэгжилтийг үнэлэхэд учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- Төслийн ХШҮ-ний тогтолцооны зорилго, үр дагавар, үр дүнгийн түвшин дэх төлөвлөсөн үзүүлэлтүүдэд хүрэх боломжтой, бодитой эсэхийг баталгаажуулах ;
- Төслийн ХШҮ-ний тогтолцоо ба индикаторуудыг тогтоох санал, зөвлөмжөгөх
- Индикатор тус бүрд ашиглаж болох мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох.

Мөн суурь судалгааны хүрээнд дараах дараах зорилтуудыг санал болгон ашиглалаа:

- ‘Залуучуудын Хөгжлийн Хөтөлбөр’-н үр нөлөөг үнэлэх ХШҮ-д шаардагдах тоон ба чанарын судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- Сэтгэл ханамжийн түвшин ба мэдлэг, хандлага, дадал гэх мэт тоон аргаар хэмжигдэх гол шалгуур үзүүлэлтүүдийн өнөөгийн түвшинг тодорхойлох;
- ‘Залуучуудын Хөгжлийн Хөтөлбөр’-ийн хүрээнд хамруулах, сайжруулах шаардлагатай асуудлыг тодруулах

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Суурь судалгаанд өсвөр насныхан, оюутан, хөгжлийн бэрхшээлтэй, ажилтай, ажилгүй, сургууль завсардсан, малчин, уурхайчин, гэрээсээ хол амьдарч буй залуучууд, үндэсний цөөнх, ЛГБТ (лесби, гей, бисекс, трансжендер) гэх мэт залуусын 11 бүлгийг хамруулсан. Мөн төслийн гол оролцогч талууд, төсөл хэрэгжүүлэгчид болон хамтран ажиллагч байгууллагуудыг судалгаанд хамруулсан.



2014 ОНЫ
12 сараас

2015 ОНЫ
3 сар



1600 АСУУМЖ



61 ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА



60 ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага


ЩХА болон НҮБХАС, Люксембургийн засгийн газрын санхүүжилтээр, МУ-ын ЗГ-тай хамтран Залуучуудын Хөгжлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Уг хөтөлбөрийн зорилго эрэгтэй, эмэгтэй залуучуудын тэгш байдлыг хангах, жөндөрт суурилсан хүчирхийлэл, төлөвлөөгүй жирэмслэлт, ХДХВ/ДОХ-ын эрсдэлийг бууруулах, нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил, ялангуяа олборлох салбарын эрчимтэй өсөлтийн үр шимийг тэдний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэж буй юм.

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээний, үнэлгээний хүрээ нь амьдрах ухааны чадвар, жөндөрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, залуучуудад чиглэсэн бодлого, нөлөөллийн ажил гэсэн 4 багц асуудлаар 4 зорилго, 12 зорилтыг хэмжих 21 шалгуур үзүүлттэй бөгөөд эдгээр шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг үнэлэх нь судалгааны гол зорилго юм.

Арга зүй

Суурь судалгааг гүйцэтгэхдээ хагас туршилтын дизайн ашиглав.

Тасалдалттай, хугацаат цувааны хагас туршилтын дизайн



A1- Зорилтот бүлгийн суурь судалгааны үр дүн,
B1- Хяналтын бүлгийн суурь судалгааны үр дүн

A2- Зорилтот бүлгийн давтан судалгаа-1-ийн үр дүн, B2- Хяналтын бүлгийн суурь судалгааны үр дүн

X1- Өөрчлөлт

A3- Зорилтот бүлгийн давтан судалгаа-2-ийн үр дүн, B3 Хяналтын бүлгийн суурь судалгааны үр дүн

X2- Өөрчлөлт

Судалгаанд оролцохоор сонгогдсон 10 гаруй залуучуудын бүлгээс асуумж болон фокус бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Чанарын аргаар мэдээлэл цуглуулахдаа картын арга, Н-хүснэгтийн арга, ойлголтын зураглал гэх мэт оролцооны аргыг ашигласнаараа онцлог. Асуумжийн аргыг залуучуудын амьдрах ухааны чадвар, жөндөрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, залуучуудад чиглэсэн бодлого хөтөлбөрийн талаарх мэдлэг мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход ашигласан. Харин фокус бүлгийн ярилцлага нь тухайн тоон судалгааны үр дүнг тайлбарлах, тодруулахад ашиглагдсан. Нийт 1600 асуумж авч, 60 фокус бүлгийн ярилцлага гүйцэтгэсэн.

Мөн нийт 61 төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төлөөллийг судалгаанд хамруулсан.

Үр дүн

Амьдрах ухааны чадвар. Залуучууд амьдрах ухааны чадварын талаарх суурь мэдээлэлтэй байна. Монгол залуучууд амьдрах ухааны чадварын талаар суралцаж байгаа, сайн мэдлэгтэй гэж 50 орчим хувь нь өөрсдийгөө үнэлж байна. Уг хөтөлбөрт залуучууд сэтгэл ханамжтай (71.3%) байна. Тэд амьдрах ухааны чадваруудыг сургуулийн хөтөлбөр, гэр бүл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээс олж мэдэж, суралцаж байна.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Жендэрт суурилсан хүчирхийлэл.

Залуучуудын хувьд 'Жендэрт суурилсан хүчирхийлэл' хэмээх ойлголт танил бус байна. Хүчирхийллийн талаарх цогц эерэг хандлагатай залуучууд дөнгөж 1.3%-ийг эзэлж байна. Орон нутгийн 3 залуу тутмын нэг нь тухайн орон нутаг дахь ЖСХ-ийн тохиолдлын талаар мэдэж байгаа нь ЖСХ нэлээд нийтлэг байж болзошгүйг харуулж байна. ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ огт байхгүй, эсвэл хүртээмж муутай байна. Залуучуудын дунд ЖСХ-ээс сэргийлэх хамгийн эрэлттэй арга зам нь үүнийг хичээлийн хөтөлбөрт тусгах явдал юм.

Бэлгийн бөлөн нөхөн үржихүйн эрүүл мэнд.

Залуучуудын дунд БЗДХ-ын талаарх зөв мэдлэг бага байна. Ялангуяа үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй залуучууд БЗДХ-ын талаар мэдлэг муутай байна. Залуучууд гэр бүл төлөвлөлтийн талаарх ойлголт төрөлтийн дараах хүүхдийн

асаргаа сувилгаа болон өрхийн орлого, зарлага, төсвөөр хязгаарлагдаж байна. Залуучуудын 75.2% нь 'Өсвөр үе, залуучуудад ээлтэй клиник'-ийн талаар огт мэдэхгүй, эсвэл сонссон төдий байна

Залуучуудад чиглэсэн бөдлөгө, хөтөлбөр.

Залуучуудын оролцоог дэмжсэн арга хэмжээ, бодлого хөтөлбөрийн хүтээмж бага байна. Судалгаанд оролцсон залуучуудын 76.1 хувь нь тэдэнд чиглэсэн ямар нэгэн хөтөлбөр, стратегийн талаар сонсож байгаагүй ажээ. Мөн залуучууд өөрсдийнх нь нийгмийн оролцоог дэмжсэн, шийдвэр гаргагчдаар асуудлаа шийдвэрлүүлэх оролцооны ажлын талаар огт дурдаагүй. Энэ нь залуучуудад чиглэсэн арга хэмжээ явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтгүй, залуучуудын онцлог, хэрэгцээнд чиглээгүйтэй холбоотой байна.



THE
WORLD
BANK



САНГИЙН ЯАМ

ХӨГЖЛИЙН АЛБАН ЁСНЫ ТУСЛАМЖИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ– ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



Захиалагч: Дэлхийн банк, Сангийн яам

Зөвлөх үйлчилгээний зорилго, зорилт:

Зөвлөх үйлчилгээний үндсэн зорилго нь төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн засаг, захиргааны нэгжийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн засаг, захиргааны нэгжийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нийт 100 мэргэжилтэнг сургалтанд хамруулж, сонгогдсон 4 төсөлд ХШҮ хийхэд зааварчилгаа өгч ажилласан.

Хэрэгцээ шаардлага

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5.6-д “Төрийн бодлого, үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, дүн шинжилгээний чадавхи, үр нөлөөг дээшлүүлнэ” гэж заасан ба 2008 оноос бүх яам болон аймгийн засаг даргын тамгын газар бүр хяналт-шинжилгээ үнэлгээний (ХШҮ) тасагтай болсон боловч чадавхи дутмаг, арга зүйн хангалттай зааварчилгаа байхгүйгээс тус ойлголт нь Монгол улсын хэмжээнд шинэ хэвээр байна.

Түүнчлэн Дэлхийн банк болон Азийн Хөгжлийн банкны хамтарсан Монгол улсын нөхцөл байдлын үнэлгээний дүнд бүх шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи сул ба тус ажилд төрөөс анхаарал бага хандуулдгыг илрүүлсэн байна. Иймээс хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг сайжруулах зөвлөмж гаргасан.

Үр дүн

Дэлхийн банкны техник туслалцааны хөрөнгөөр Сангийн яам нь “Хөгжлийн албан ёсны тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх систем нэвтрүүлэх төсөл” – ийг хэрэгжүүлсэн бөгөөд уг төсөл нь гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн системийг нэвтрүүлэх замаар төслүүдийн хэрэгжилтийг удирдан зохицуулах Засгийн газрын чадавхийг сайжруулах зорилготой юм.

Уг зөвлөх үйлчилгээ нь 3 үндсэн үйл ажиллагаанаас бүрдсэн.

1-р үйл ажиллагааны хүрээнд Хөгжлийн албан ёсны тусламжийн төслүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг сайжруулах гарын авлага гаргасан. Гарын авлага нь төслийн удирдлагаас эхлүүлээд төслийн нөлөөллийн үнэлгээ, төслийн хаалтын тайлан хүртэл бүх үе шатыг агуулсан ба сургалтын хэрэглэгдэхүүн, практик гарын авлага байхаар төлөвлөж бичсэн тул онолын тайлбар, дүрэм журмаас аль болох бага оруулсан.



2015 оны
2 сараас

2015 оны
4 сар



100 ОРОЛЦОГЧ

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

2-р үйл ажиллагааны хүрээнд төрийн албаны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан орон нутгийн 40, яам тамгын газрын 60 оролцогчдод хоёр өдрийн практик сургалт зохион байгуулсан. Сургалт нь 3-р сарын 9-с 3-р сарын 19 хүртэл нийт 8 өдөр 4 ээлжээр тус бүр 2 өдрийн сургалт хийгдсэн ба сургалтын төгсгөлд оролцогч бүрт Сангийн яамны төрийн нарийн бичгийн гарын үсэгтэй сертификат гардуулсан юм.

Сургалтаар оролцогчдод төслийн мөчлөг, ХШҮ-ний үндсэн ойлголтууд, нэр томъёо, арга зүйг заасан ба сургалтын турш бие даасан дасгал ажил, багийн ажил гүйцэтгэсэн практик сургалт болж чадсан юм.

Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэгийг үнэлэхэд 10-50 хувь хүртэл мэдлэг хамгийн их хэсгийг эзэлж бүтэн оноо авах оролцогч байгаагүй бол сургалтын дараах үнэлгээгээр 50-иас доош хувийн үзүүлэлттэй оролцогчийн хувь эрс багасч өндөр оноотой оролцогчийн тоо нэмэгдсэн ба сургалтыг дахин зохион байгуулах санал хүсэлт их ирж байснаас сургалт амжилттай болсон гэж дүгнэж болох юм.

Тестийн дүн



3-р үйл ажиллагааны хүрээнд Сангийн яамнаас сонгосон дараах дөрвөн төсөл дээр үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд нь ХШҮ-ний мэргэжилтнүүдэд зааварчилгаа өгөн ажилласан юм.

- 1) Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл
Хэрэгжүүлэгч: Барилга хот байгуулалтын яам
Санхүүжүүлэгч: Азийн Хөгжлийн Банк
- 2) Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн төсөл
Хэрэгжүүлэгч: Зам тээврийн яам
Санхүүжүүлэгч: БНХАУ
- 3) Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл
Хэрэгжүүлэгч: Сангийн яам
Санхүүжүүлэгч: Дэлхийн банк
- 4) Дээд боловсролын шинэчлэлийн төсөл
Хэрэгжүүлэгч: Боловсролын яам
Санхүүжүүлэгч: Азийн Хөгжлийн Банк

ХШҮ-ний тэргүүн туршлагыг хэрэгжүүлэхэд дараах гурван үе шат бүхий үйл ажиллагааг гүйцэтгэсэн:

1. Төсөлтэй танилцах, бичиг баримтын шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах үүднээс ИРИМ-ийн зөвлөхүүд төсөл хариуцсан яамны албан хаагчид болон төсөл хэрэгжүүлэх нэгжтэй уулзалтууд зохион байгуулсан,
2. Төсөл хэрэгжүүлэгч яамны ХШҮ-ний мэргэжилтэн ИРИМ-ийн зөвлөхүүдийн хамтаар төслийн логик хүрээ болон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан,
3. ИРИМ-ийн зөвлөхүүд мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ХШҮ-ний үйл явцыг цаашид сайжруулах зөвлөмжийг төсөл тус бүрээр боловсруулсан.



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun Svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

“ЗОРИЛТОТ БУЛГИЙН ДУНД МЭДЛЭГИЙН ТӨВ БАЙГУУЛАХ СУДАЛГАА”



Захиалагч: Швейцарийн хөгжлийн агентлаг

Хамтрагч: Тогтвортой Бичил Уурхай төсөл

Судалгааны зорилго, зорилт


Төслийн зорилготой уялдан, судалгаа нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

- Бичил уурхайчид, орон нутгийн удирдлагатай харилцах орон нутгийн онцлогт тохирсон мэдээллийн хамгийн үр дүнтэй, хэмнэлттэй арга замыг олж тодорхойлох
- Мэдлэгийн төвийн цахим хуудсыг зорилтот бүлэгт илүү үр өгөөжтэй болгох

Түүнчлэн “Тогтвортой Бичил Уурхай” төслийн талаарх иргэдийн дундах санаа бодол ойлголтыг тодорхойлохыг зорьсон.

Төслийн үр дүнд үндэслэн Мэдлэгийн төвийн олон нийттэй харилцах аргачлалыг боловсруулсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Монгол улсын 9 аймгийн 15 сум болон Улаанбаатар хот



2015 ОНЫ
4 сараас

2015 ОНЫ
6 сар



364 АСУУМЖ



19 ЯРИЛЦЛАГА



8 ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаарлага

“Тогтвортой Бичил Уурхай” төслийн 4-р үе шат Монгол улсыг Бичил уурхачдын олон улсын тэргүүн туршлагын мэдлэгийн төв болгохыг зорьж буй юм. Энэ хүрээнд төсөл нь Монгол улсад эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан, олон улсын бичил уурхайн тэргүүн туршлагаас суралцах, түүнд хувь нэмэр оруулах Бичил уурхайн салбарыг бий болгох зорилго дэвшүүлсэн.

Мэдлэгийн Төв гэсэн төслийн бүрэлдэхүүн нь төслийн үр нөлөөг үндэсний түвшнээс гаргаж, эргүүлээд олон улсын туршлагыг Монголд авчрах юм.

Арга зүй

Судалгааны анхдагч мэдээллийг асуумж, ганцаарчилсан ярицлага, фокус бүлгийн ярилцлагын аргаар цуглуулсан бол хоёрдогч мэдээллийг статистикийн эх сурвалжаас ашигласан.

Түүврийн бүтэц Судалгаанд 454 иргэн оролцсон Тухайлбал:

- 8 фокус бүлгийн ярилцлага
- 19 удаагийн гүнзгийрүүлсэн ярилцлага
- 364 асуумж

Үр дүн

Хэдийгээр төслийн мэдээллээс харахад цахим хуудаст суурилсан МТ нь ТБУ төслийн хавьд хамгийн тохиромжтой хэлбэр байсан ч судалгаа нь цахим хуудаст суурилаагүй бусад арга замыг бий болгох боломжийг тодорхойлохыг давхар зорьсон.

Мэдээллийн эх үүсвэр, хүртээмж

Судалгаанд оролцогчдын олонхи (94,2%) нь өдөрт дунджаар 3,8 цаг телевиз үздэг байна. Харин интернэтийн хэрэглээ хязгаарлагдмал буюу зөвхөн 23,6 хувь нь ашиглаж байна. Интернэт ашиглалт өдөрт дунджаар 2,1 цаг байна. Эндээс үзэхэд телевиз нь хамгийн хүртээмжтэй мэдээллийн эх үүсвэр болж байна. Интернэт хэрэглэгчдийн хамгийн их зочилдог цахим хуудас нь Фэйсбүүк (58.69) байна. Судалгаанд хамрагдсан интернэт хэрэглэгчдийн 91.6 хувь нь Бичил уурхайчдын хэрэгцээнд зориулсан Фэйсбүүк хуудсыг ашиглана гэж мэдэгдсэн байна.

Бичил уурхайчдын мэдээллийн эх үүсвэрийн хувьд хамгийн чухал тав нь дараах хэрэгслүүд байв. Үүнд:

ТББ-ын үйл ажиллагаа	19.9%
Иргэдийн уулзалт (ТББ, төсөл, г.м.)	19.3%
Бичил уурхайчид	16.1%
Телевиз	14.9%
Төслийн үйл ажиллагаа	11.5%

Телевиз нь мэдээллийн хэрэгслүүдээс хамгийн өндөр хувьтай байгаа ч бичил уурхайчдын уул уурхайн талаар мэдээлэл авдаг гол эх үүсвэрүүдийн 4-т орж, харин ТББ, иргэдийн уулзалт, бичил уурхайчид өөрсдөө гэсэн хариултуудын дараа орлоо.

Мэдлэгийн төвийн хүрээ

Хамгийн тохиромжтой гурван арга хэрэгсэл нь:

1. Гар утас; ихэнх оролцогч ТББ, ялангуяа ахлагч, ТБУ төсөл болон БУНДХ хариуцах,
2. Уулзалт; дээрхтэй ижил.
3. Телевиз; ТББ, ТБУ төсөл хариуцах ба хамгийн их үздэг суваг нь МҮОНТ, орон нутгийн телевиз, TV9, “Малчин” телевиз.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүсиэгт 1. Мэдээллийн хэрэгслүүдийн арга хэлбэрийг ФБЯ-аар гүизгийрүүлэн тодорхойлсон байдал

Мэдээллийн хэрэгсэл	Хариуцах эзэн	Төвлөрөх газар	Давтамж
Гар утас	ТББ,ТБУ төсөл,БУНДХ	--	Долоо хоног тутам
Уулзалт	ТББ,ТБУ төсөл,БУНДХ	Сумын төв	Сар тутам
Телевиз	ТББ,ТБУ төсөл	МҮОНТ Орон нутгийн телевиз TV9 "Малчин"	Сар тутам
Тараах материал	ТББ	Талбарт	Сар тутам
Интернэт	ТББ	Facebook Тусгай вэбсайт	Долоо хоногт 2-3 удаа
Туршлага судлах аялал	Нөхөрлөлийн ахлагч	Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	Жилд хоёр удаа
Ам дамжсан яриа	Бичил уурхайчид	--	--

Төсөл МТ-ийн уулзалтууд зохион байгуулах тохиолдолд уулзалтын хамгийн тохиромжтой байршлыг дараах байдлаар сонгосон. Үүнд:

Ажлын талбар дээр	52.5%
Сумын төвд	36.3%
Аймгийн төвд	8.2%
Бусад ⁵	2.9%

Хамгийн тохиромжтой давтамж нь сард нэг удаа гэж үзэж байна.


Улиралд нэг удаа	27.1%
Сард нэг удаа	51.9%
2 долоо хоногт нэг	9.0%
Долоо хоног тутам	5.1%
Бусад	7.0%

ФБЯ-аар мөн дараах саналуудыг гаргав. Үүнд:

- Тараах материалыг ТББ бэлтгэн, сард нэг удаа талбар дээр тараах,
- Интернэтэд суурилсан МТ нь Facebook болон бусад вэбсайтыг ашиглах,
- Туршлага судлах аялалыг Баянхонгор аймаг, тэрдундаа Баян-Овоо суманд очиж зохион байгуулах, учир нь тэндхийн бичил уурхайн бүлэг, үйл ажиллагаа нь харьцангуй сайн хөгжсөн гэж үздэг,
- Ам дамжсан яриа мөн нэг сонголт байж болно. Зарим хүн энэ нь найдвар багатай ч маш өртөг багатай, хугацаа хэмнэсэн гэж үзсэн.

Эдгээр үр дүн, дүгнэлт нь одоогийн бодит нөхцөл байдалд тулгуурласан ба ирээдүйн хэрэгцээ шаардлага, боломжийг арай бага тусгасан болно.

“БИЧИЛ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЗАМААР ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ



Захиалагч: АДРА Монгол ОУБ **Судалгааны зорилго, зорилт**

Энэхүү судалгаа нь “Бичил бизнесийг дэмжих замаар ядуурлыг бууруулах” төслийн үр дүнг хэмжих зорилготой. Үүний тулд:

1. Төслийн үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнг үнэлэх, хэрэгжилтийн дараах үнэлгээний мэдээллээр хангах;
2. Зорилтот бүлгийн үйл ажиллагааны тогтвортой байдал, орлогын түвшин, сэтгэл ханамжийн түвшин дэх өөрчлөлтийг тогтоох;
3. Төсөлд оролцогч талуудын оролцооны түвшин, төслийн зорилгын талаарх ойлголтын түвшин, хамтран ажилласан байдлыг үнэлэх;
4. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний улс орны бодлого хөтөлбөртэй уялдаа хамааралтай байдал, үр ашигтай биелэлтийг үнэлэх
5. Хөтөлбөртэй холбоотой амжилттай болон амжилтгүй туршлагыг илрүүлэх зэрэг зорилт дэвшүүлсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Судалгааны хүрээнд “PRIME UB” төслийн үр шим хүртсэн бичил бизнес эрхлэгчид, төслийн хэрэгжүүлэгч талууд, дүүргүүдийн удирдлагуудаас мэдээлэл цуглуулсан.

Хэрэгцээ шаардлага

Уг төсөл нь 2010-2015 онд Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилго дэвшүүлсэн. Голлон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь:

- Бичил бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэх мэдлэгийг сайжруулах
- Тэднийг санхүүгийн үйл ажиллагаанд хамруулах, зуучлах /зээл, хадгаламж, даатгал гэх мэт/
- Бизнес эрхлэх орчин нөхцөлийг сайжруулах.

Арга зүй

Төслийн хэрэгжилт, үр дүнг үнэлэхдээ дараах аргачлалд тулгуурласан.

- Эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг сонгосон.
- Үр шим хүртэгчид ба төслийн хэрэгжүүлэгч талуудын байр суурийг чанарын болон тоон судалгааны аргаар мэдээлэл цуглуулж харьцуулан үнэлсэн.
- Харьцуулагдахуйц байх – Төслийн суурь судалгааны үр дүнд анхаарал хандуулж, төслийн хэрэгжилт, үнэлгээ, санал дүгнэлтийг хийхдээ харьцуулан авч үзсэн

Судалгааны мэдээлэл цуглуулалтад баримт бичгийн судалгаа, асуумж, фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлагын аргуудыг ашигласан.



2015 ОНЫ
4 сараас

2015 ОНЫ
6 сар



170 АСУУМЖ



10 ЯРИЛЦЛАГА



5 ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанд хамрагдагчид:

- Ерөнхий сургалтад хамрагдсан үр шим хүртэгчид – 44,3% /125/
- Дараагийн шатны сургалтанд хамрагдсан үр шим хүртэгчид – 8.9% /25/
- Зээлийн холбон зуучлалын үйлчилгээнд хамрагдсан үр шим хүртэгчид – 30.7% /85/
- Хадгаламж, даатгалын үйлчилгээнд хамрагдсан үр шим хүртэгчид – 5.4% /15/
- Оюутын сайн дурын хөтөлбөрт хамрагдсан үр шим хүртэгчид – 5.4% /15/
- Өөрөө өөртөө туслах бүлгийн хөтөлбөрт хамрагдсан үр шим хүртэгчид – 5.4% /15/

Төслийн үр дүнг судалгаанд оролцогчдын 25,9 хувь нь маш сайн, 60 хувь сайн гэж үнэлсэн байна. Мөн бүлгийн хэлэлцүүлэгт хамрагдсан оролцогчдоор төслийн үр дүнд, үр нөлөөг 1-10 оноогоор дүгнүүлэхэд, дунджаар 8.1 оноо өгсөн. Өөрөөр хэлбэл, төслийн үр шим хүртэгчид төслийн хэрэгжилт, үр дүнд сэтгэл ханамжтай байна.

Үйл ажиллагааны үнэлгээ (Сургалт)



Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 72,9 хувь нь сургалтанд хамрагдсанаар сертификат авсан байна.

Эдгээр үр шим хүртэгчдээс сургалтаар олж авсан мэдлэгээ өөрийн бизнес, үйл ажиллагаандаа хэрэглэсэн эсэх асуултанд 78,2 хувь нь 'Тийм' гэж хариулжээ.

Бичиг бизнесийг дэмжих үйл ажиллагааны үнэлгээг үйлчилгээний төрлөөр



Даатгал болон зээлийн батлан даалтанд хамрагдсан иргэд дундаас дээш үнэлгээг өгсөн байхад зээлийн зуучлал, хадгаламжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тодорхой хувь нь муу үнэлгээг өгчээ.

Эцэст нь, судалгаанд оролцсон үр шим хүртэгчдийн өгсөн санал зөвлөмжүүдээс хамгийн их хувь нь (42,9%) “төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх”, 16,1 хувь нь “зорилтот бүлэгт хүрэх хүртээмжээ сайжруулах” гэсэн санал зөвлөмж өгсөн байгаагаас үзэхэд төсөл цаашид үйл ажиллагаагаа явуулах бодит хэрэгцээ шаардлага байгаа нь харагда байна.

УСНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Захиалагч: Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/

Төслийн зорилго, зорилт

ОУСК нь уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлага, малчид иргэдтэй хамтран ажиллах замаар Өмнөговь аймаг дахь талуудын усны талаарх мэдлэгийг дээшлүүлж, энэ асуудлаар нээлттэй ярилцах үүд хаалгыг нээж, усны нөөцийн менежментийн хүрээнд хамтран ажиллах боломжийг бий болгохоор зорьж байна.

2013 онд IRIM судалгааны хүрээлэн ОУСК-ийн хүсэлтээр Өмнөговь аймагт “Усны талаарх иргэдийн мэдлэг хандлагыг тодорхойлох судалгаа”-г зохион байгуулсан.

Энэ удаагийн хэлэлцүүлгийн зорилго нь ус ба түүнийг тойрсон асуудлаар талуудад нэгдсэн ойлголт өгч, орон нутгийн усны менежмент дэх оролцоог бэхжүүлэхэд чиглэсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн 15 сум

Хэрэгцээ шаардлага

2007 оноос Монгол Улсын Засгийн Газар, Дэлхийн банк, уул уурхайн компаниуд хамтран говийн бүсэд чиглэсэн Бүсийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хүрээнд усны нөөцийн менежментийн асуудалд чухал ач холбогдол өгч ажиллаж байна. Тухайлбал говийн усны одоогийн ба цаашдын нөөц, усны хэрэглээ, иргэдийн мэдлэг хандлага, оролцоонд чиглэсэн ажлууд нэлээд хийгдсэн.



2015 ОНЫ
6 сараас

2015 ОНЫ
10 сар



301 ОРОЛЦОГЧ



15 ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:

9 сарын 11-16-ны өдрүүдэд Өмгөговь аймгийн 15 сумдад 15 хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сүүлийн хэлэлцүүлэг нь ОУСК-ийн уул уурхай болон усны менежментийн чиглэлийн урт хугацааны нөлөөллийн ажлын нэг хэсэг байсан.

Хэлэлцүүлгүүдэд нийт 301 оролцогч хамрагдсан:

- 2013 оны ОУСК-ийн Санаа бодлын судалгааны оролцогчид,
- 2014 ОУСК-ийн сургалт, хэлэлцүүлгийн оролцогчид,
- Бусад буюу үндэсний, аймгийн, сумын байгууллагын төлөөлөл, ТББ, орон нутгийн иргэд байв.

Хэлэлцүүлгүүдийн 5 мөн орон нутаг дахь уул уурхайн үйл ажиллагаа явуулагч байгууллагын төлөөллийг хамруулсан. Хэлэлцүүлгүүдийн оролцогчид (56.1 хувь нь эмэгтэй байсан) нь дараах зүйлсээр хангагдсан:

- 2013 оны Санаа бодлын судалгааны хураангуй (32 хуудас бүхий гарын авлагын хамтаар)
- 2014 оны сургалтын агуулгыг хураангуйлсан баримтат хуудас.

Оролцогчдоос мөн 2014 оны сургалтын үр дүнд бий болсон зан үйлийн өөрчлөлтийн жишээ дурьдах, уул уурхай болон усны менежментийн холбоотой мэдээллийн шаардлагыг тайлбарлах, аль сувгаар эг мэдээллийг авахыг илүүд үзэж буй болон оролцогч талуудын оролцоог хангах боломжийг тодорхойлохыг хүссэн.

Хэлэлцүүлэгт оролцогчид өндөр ач холбогдол өгсөн бөгөөд тэдний 91,1 хувь нь хэлэлцүүлгийг “маш хэрэгтэй” эсвэл “хэрэгтэй” гэж дүгнэсэн. Мөн түүнчлэн: More particularly:

- 88.7% нь гарын авлагыг “маш хэрэгтэй” эсвэл “хэрэгтэй”
- 85.4% нь баримтат хуудсыг “маш хэрэгтэй” эсвэл “хэрэгтэй” гэж тус тус үнлэжээ.

Хэлэлцүүлгийн оролцогчид нь 2013 судалгааны асуулгыг дахин бөглөсөн бөгөөд судалгааны үр дүнгээс нөлөөллийн 2 жилийн хугацаанд санаа бодол төдийлөн өөрчлөгдөөгүй нь харагдсан.

2014 оны сургалтанд хамрагдаж байсан оролцогчдын 36 (67,4%) нь ОУСК-ийн өмнөх санаачлагын талаар өргөн хүрээтэй боловч ерөнхийдөө эерэг болон үр нөлөөтэй гэж дүгнэсэн. Хорин хүн мэдлэг олж авсан гэж дурдсан. Дөрөв нь тэдний авч хэрэгжүүлсэн санаачлагын талаар тодорхой жишээ дурдсан бол 13 нь ирээдүйд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй саналуудыг тайлбарласан.

Хэлэлцүүлгийн оролцогчид усны талаар ихээхэн санаа зовж буй нь 2015 оны хэлэлцүүлгийн үеэр илт байсан. Олон оролцогчдын хувьд усны зохих ёсны шинжилгээ болоод үр дүнг ил тод нийтлэх нь бүх талуудын ойлголцлыг усны холбогдолтой зарим асуудлаар дээшлүүлнэ гэсэн тодорхой бодолтой байв.

Хэлэлцүүлгүүдийн гол хэсэг болох 50 удаагийн бүлгийн ажил нь шинжилгээнд ашиглахуйц маш их мэдээллийг өгсөн. Тухайлбал усны менежментэд талуудын оролцоог хангах 457 санал гарсан. Саналуудыг дараах 7 бүлэгт хувааж авч үзсэн:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон мэдээллийн түгээлт,
- Шинэ усны эх үүсвэрээр хангах, одоо байгааг засаж сэлбэх,
- Сургалт,
- Усны эх үүсвэрүүдийг хамгаалах,
- Усны хэрэглээнд өөрчлөлт хийх,
- Нөхөн сэргээлт,
- Бусад.

ХШҮ болон мэдээллийн түгээлт нь хамгийн түгээмэл бүлэг санал байв. Харин бусад гэсэн хэсэгт шашны зан үйл, уул уурхайг хориглох, ерөнхий төсөв болон бодлогын асуудал, уулзалт зохион байгуулах болон хамтарсан төлөвлөлт хийх гэх мэт маш олон янзын саналууд багтсан.

“ЦХА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ 2013-2016”




Захиалагч: Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)

Хамтрагч: Ногоон Алт, Монгол төмс, Техник мэргэжил Болосврол Сургалт, ОНХС, Тогтвортой бичил уурхай төслүүд

Судалгааны зорилго, зорилт

2015 оны Хяналт Шинжилгээ, Үнэлгээний гол онцлог нь ШХАГ-ын Хамтын Ажиллагааны 2013-2016 оны Стратегийн хяналт шинжилгээ, үнэлгээний нэг үе шат бөгөөд 2013, 2014 онд хийгдсэн суурь болон давтан судалгааны шалгуурын гүйцэтгэлийг үнэлэхэд оршино. Түүнээс гадна, 2015 оны Хяналт Шинжилгээ, Үнэлгээ нь ШХАГ-ын “Тогтвортой бичил уурхай” төсөл болон түүнд холбогдох асуудлуудад шинээр анхаарал хандуулсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ: Баруун болон төвийн бүсийн 9 аймгийн 32 сум
(Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Увс, Архангай, Өвөрхангай, Төв)



2015 ОНЫ
5 сараас

2015 ОНЫ
10 сар



1780 АСУУМЖ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2017 оны стратегийн зорилго бол Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах явдал юм. ШХА уг стратегийн зорилгоо (1) ХАА, хүнсний аюулгүй байдал; (2) Мэргэжлийн боловсролын сургалт; (3) Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоо гэсэн чиглэлд дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ. Мөн, тогтвортой бичил уурхай болон тогтвортой хөгжлийн боловсрол гэх мэт төслийг санхүүжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт, оролцоо бүрийг үр дүнгийн хэрэгслээр дамжуулан төлөвлөж, удирдаж, хянана. Хамтын ажиллагааны шинэ стратегийн үр дүнг улсын түвшинд болон Швейцарийн хамтын ажиллагааны түвшинд тодорхойлсон.

Арга зүй

Хяналт, Шинжилгээ Үнэлгээний мэдээлэл цуглуулалтыг асуумжийн аргаар цуглуулдаг бөгөөд 2015 оны Давтан судалгааны хувьд төслүүдийн хамаарлаас шалтгаалан 8 төрлийн асуумж ашигласан. Үр дагаврын индикаторуудыг хэмжихдээ хувь хүний мэдээллээс гадна өрхийн мэдээллийг тодруулсан. Энэ судалгаанд нийт 1780 хүнийг хамруулсан.

Үр дүн

2013 оны Суурь судалгааны дараа, 2014 оны ХШҮ-ний судалгаанд ШХАГ-ын 'Захиргааны шинэтгэл, Орон нутгийн засаглал, Иргэний оролцоо' болон 'Мэргэжлийн Боловсрол, Сургалт' салбар төслүүд; түүнд холбогдох Орон Нутгийн Хөгжлийн Сан ба Мэргэжлийн Боловсрол Сургалт зэрэг асуудлыг нэмж судалж байсан. Үүнтэй адилаар, 2015 оны ХШҮ-ний судалгаагаар 'Бичил уурхайг (БУ) албан ёсны зохион байгуулалттай болгох талаарх олон нийтийн санал бодол'-ыг шинээр анхаарлаа хандуулан судалсан.

Харин 2013 оны Суурь судалгаа болон 2014 оны ХШҮ-ний судалгаанаас ялгаатай нь, УНМ төслийн талаар мэдээллийг 2015 оны ХШҮ-ний судалгаанд авч үзээгүй.

Судалгаанд хамрагдсан үр шим хүртэгчдийн (гурван салбар төсөл болон БУ төсөл) ерөнхий онцлогийг тайлбарлах хэсэг нь Эцсийн Тайлангийн дийлэнхи хэсгийг бүрдүүлж байгаа. ШХАГХамтын ажиллагааны газрын түвшин дэх шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнг 2015 оны ХШҮ-ний судалгаагаар тодорхойлж, дараах хүснэгтэд хураангуйлан харууллаа:



The Asia Foundation

ХОТЫН ЗАСАГЛАЛ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



Захиалагч: АНУ-ын Азийн сан
Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь Хотын засаглал төслийн нарийвчилсан үйл ажиллагаа хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, төслийн дизайныг боловсруулах явдал байв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сонгигохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 32 хороо.



2015 ОНЫ
5 сараас

2015 ОНЫ
5 сар



866 ИРГЭН

108 ХОРООНЫ
АЖИЛТАН

20 ДҮҮРГИЙН
АЖИЛТАН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаарлага

АНУ-ын Азийн сан нь зорилтот дүүргүүдэд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, иргэдийн оролцоог дэмжихын тулд өнөөгийн төрийн үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой Хотын засаглал төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү судалгааны гол зорилго нь Хотын засаглал төслийн нарийвчилсан үйл ажиллагаа, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, төслийн дизайныг боловсруулах явдал байв.

Үр дүн

Төрийн үйлчилгээ

Иргэд болон дүүрэг, хорооны ажилтнуудаас тухайн хороодод хамгийн ихээр тулгамдаж байгаа асуудлын талаар тодруулсан.

#	Үйлчилгээ	Иргэд	Хорооны ажилчид	Дүүргийн ажилчид
1	Газар төлөвлөлт, зохион байгуулалт	12.0%	13.3%	15.0%
2	Агаарын бохирдол	11.1%	5.1%	20.0%
3	Хөрсний бохирдол	10.0%	13.8%	6.7%
4	Ажилгүйдэл	14.2%	13.8%	5.0%
5	Амжиргааны түвшин	8.2%	9.2%	6.7%
6	Орчны тохижилт	12.5%	14.3%	8.3%
7	Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж	7.3%	11.2%	10.0%
8	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж	4.5%	3.6%	6.7%
9	Аюулгүй байдал, гэмт хэрэг	3.5%	3.1%	5.0%
10	Нийтийн үйлчилгээ	7.2%	3.1%	8.3%
11	Дэд бүтэц зам тээвэр	9.6%	9.7%	8.3%
	Нийт	100.0	100.0%	100.0%

Хорооны иргэд болон ажилтнууд ажилгүйдэл, орчны тохижилтыг хамгийн тулгамдсан асуудал гэж үзэж байна. Мөн газар төлөвлөлт, зохион байгуулалтын асуудал ч чухал ач холбогдолтой байна. Харин дүүргийн ажилтнууд агаарын бохирдол зэрэг асуудалд илүү ач холбогдол өгсөн.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Төрөөс иргэдэд хүргэж буй хамгийн түгээмэл үйлчилгээнүүдийн чанар, хүртээмжийг 1-5 оноогоор үнэлүүлэхэд дараах үр дүн гарсан.

№	Үйлчилгээний төрөл	Иргэд (Хорооны ажилтнууд	Дүүргийн ажилтнууд
1	Иргэний бүртгэл, мэдээлэл	3.7	4.1	3.9
2	Жижиг, дунд үйлдвэрийн зээлэнд хамруулах, бизнесийн сургалт, зуучлал	2.8	3.6	3.6
3	Газрын харилцаа	2.7	3.3	3.2
4	Нийгмийн халамж	3.5	3.9	4.0
5	Өрхийн эмнэлэг	3.6	3.6	3.2
6	Дүүргийн эрүүл мэндийн төв	3.2	3.3	3.4
7	Сургууль	3.1	2.5	2.8
8	Цэцэрлэг	2.6	2.4	2.4
9	Цагдаагийн хэсэг	3.5	3.6	3.3
10	Гал түймэр, үер гэх мэт аюулаас урьдчилан сэргийлэх	3.3	3.6	3.4
11	Цахилгаан хангамж	3.6	3.5	3.2
12	Цэвэр ус хангамж	3.6	3.5	3.3
13	Гудамж, орчны тохижилт	2.7	2.8	3.3
14	Гудамжны гэрэлтүүлэг	3.2	3.4	3.3
15	Хог хаягдлын цэвэрлэгээ ачилт	3.6	4.1	3.9
16	Нийтийн тээвэр	3.5	3.2	3.5
17	Ахуйн үйлчилгээ	3.3	3.0	3.5

Үйлчилгээнүүдээс иргэний бүртгэл, мэдээллийн үйлчилгээ болон хог хаягдлын цэвэрлэгээ ачилт зэрэг үйлчилгээнүүд 'сайн' гэж үнэлэгдсэн бол цэцэрлэгийн хүртээмжийг хамгийн муу үнэлжээ.

Иргэдийн мэдлэг

Судалгаанд хамрагдсан иргэдийн 37,2 хувь (тэдний 79,9% нь иргэдийн нийтийн хууралд оролцож байжээ) нь хорооны иргэдийн нийтийн хурлын талаар, 17,7 хувь (тэдний 29,9 хувь нь ОНХС-д хичнээн төгрөг хуваарилагдсаныг мэднэ гэж хариулжээ) нь Орон нутгийн хөгжлийн сангийн талаар мэддэг гэж хариулжээ.

Иргэдийн оролцоо

Судалгаанд хамрагдсан иргэдийн 78,6 хувь нд маргааш хорооноос хурал зарлагдвал

оролцоно гэж хариулжээ. Харин оролцохгүй гэж хариулсан иргэдийн хувьд Ажилтай (62,9%), хүүхэд, өндөр настан асардаг, хөгжлийн бэрхшээлтэй (23,1%) гэсэн шалтгаанууд зонхилж байна. Иргэд хороо дүүргийн хэмжээнд тодорхой асуудлаар санал өгөх бол хурал цуглаанаар (31,2%) эсвэл гэртээ (30,7%) санал өгөхийг илүүд үзэж байна.

Иргэдийн 1/3 нь төр засгийн үйлчилгээний талаар тодорхой хэмжээнд мэдээлэлтэй байна. Иргэдэд мэдээлэл хүргэхдээ 30 хүртэлх насныханд интернэтээр, 30-40 насныханд телевизээр, 40-өөс дээш насныханд хэсгийн ахлагч, хороо, дүүргийн мэдээллийн самбараар мэдээлэл хүргэх нь илүү үр дүнтэй байна.

“МОНГОЛ УЛСЫН 1-Р АНГИЙН СУРАГЧДЫГ СУРГУУЛЬД ҮР ДҮНТЭЙ БЭЛТГЭХ, СУРАЛЦАХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХЭД СУРГУУЛИУДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ”



Захиалагч: Японы Хүүхдийг Ивээх Сан

Судалгааны зорилго, зорилт

Суурь судалгаа нь зорилтот сургуулиуд болон тухайн нутаг дэвсгэр (сургуулийн хамран сургах тойрог) дэх сургуулийн бэлтгэл буюу дасан зохицох хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тархалт, онцлог шинжийг тодорхойлох, түүнчлэн зорилтот хүүхдүүдийн (5-6 настай, бага сургуульд ороход бэлэн болсон буюу одоо суралцаж байгаа охид хөвгүүд) сургуульд бэлтгэгдсэн байдал, чадавхийг тодорхойлж, хөтөлбөрийн шийдвэр гаргахад ашиглах, төслөөс гарах боломжит үр дүн, үр нөлөөний босгыг тогтоох зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг тавьсан:

1. Зорилтот өрхүүд дэх сургуулийн өмнөх (албан ба албан бус) боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийн тархалт, онцлогийг тодорхойлох
2. Шалгуур үзүүлэлтийн суурь утгыг тодорхойлох, тухайлбал, төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн босго тогтоох
3. Зорилтот хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал болон дасан зохицох чадварыг дээшлүүлэхэд шаардагдаж буй зүйлсийг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ, үйлчилгээний талаар санал боловсруулах
4. Бодлогын нөлөөллийн ажлаар дамжуулан сургуульд суралцах бэлтгэл болон дасан зохицох асуудлаар загвар хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Судалгаанд хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхэд олонтой Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн төрийн өмчийн 20 сургуулийг хамруулсан.



2015 ОНЫ
4 сараас

2015 ОНЫ
7 сар



600 СУРАГЧ **100** ЭЦЭГ ЭХ

99 БАГШ



23 ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Монгол улс дахь Японы Хүүхдийг Ивээх Сан ба Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамтай хамтран Япон улсын Гадаад Хэргийн Яам (ГХЯ)-ны санхүүжилтээр “Монгол улсын 1-р ангийн сурагчдыг сургуульд үр дүнтэй бэлтгэх, суралцах таатай орчинг бүрдүүлэхэд сургуулиудыг чадавхижуулах” бага боловсролын төслийг 3 жилийн хугацаатай (2015-2018) Улаанбаатар хотод хэрэгжүүлж эхлээд байна.

Уг төслөөр Улаанбаатар хотын 3 дүүргийн (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан) төрийн өмчийн 20 сургуульд, зарим нь албан ёсны сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт хамрагдаж байгаагүй 1-р ангийн сурагчдад (5-6 настай охид, хөвгүүд) зориулсан сургуульд суралцах бэлтгэл хангах болон дасан зохицох асуудлаар хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Аргазүй

Суурь судалгааны мэдээллийг асуумж, ярилцлага гэх мэт тоон болон чанарын судалгааны мэдээлэл бүрдүүлэх аргаар цуглуулсан.

Суурь судалгаанд сургуульд суралцаж буй, сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан, хамрагдаагүй 1-р ангийн 600 сурагч (5-6 настай), 100 эцэг эх, 99 багш болон сургуулийн удирдлага, дүүргийн боловсролын мэргэжилтнүүд хамруулсан.

Судалгаагаар сурагчдын сурах чадвар, бэлэн байдал, эцэг эхчүүдийн хүүхдийнхээ сурах чадвар, бэлтгэгдсэн байдлын талаарх ойлголт болон хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаан дахь оролцоог нь тодорхойлсон.

Сургуулийн удирдлага болон дүүргийн боловсролын мэргэжилтнүүдэд зориулсан ярилцлагын удирдамж боловсруулсан.

Ярилцлагын аргыг ашиглан оролцогч талуудын зорилтот талбар дах хүүхдүүдийн бэлтгэгдсэн байдал болон дасан зохицох чадварын талаарх ойлголтууд, тулгарч буй асуудлууд, түүнийг сайжруулахын тулд нэн шаардлагатай хийх ажлуудыг тодруулахыг зорьсон. Судалгааны хүрээнд сургуулийн удирдлагууд болон зорилтот 3 дүүргийн сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан нийт 23 ярилцлага хийсэн.

Үр дүн

ЗОРИЛТ 1 : Хүүхдийн суралцах чадварыг хангах талаар зорилтот сургуулийн бага ангийн багш нарын мэдлэг, ойлголт чадварыг сургалтад хамруулах замаар дээшлүүлэх

- Судалгаанд хамрагдсан багш нарын 58 хувь нь сүүлийн 1 жилийн хугацаанд 1-р ангийн хүүхэд сургуульд дасан зохицоход чиглэсэн арга зүйн сургалтанд хамрагдсан, 42 хувь нь хамрагдаагүй байна.
- Багш нарын 85 хувь нь “мэдлэг”-ээ “сайн”, 88 хувь нь өөрийн “ур чадвар”-ынхаа түвшинг “сайн” гэж үнэлсэн байна.
- Багш нараар хүүхдийг сургуульд хүлээн авах талаар өөрсдийнх нь арга зүй, арга барилыг үнэлүүлэхэд 95 хувь нь “маш сайн”, “хангалттай” гэсэн эерэг үнэлгээг өгсөн бол 5 хувь нь хангалтгүй гэж үнэлсэн байна.
- Судалгаанд хамрагдсан багш нарын 50 гаруй хувь нь сүүлийн 1 жилд 1-р ангийн хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтанд хамрагдаагүй, өөрсдөө бие даан суралцах, хөгжүүлэх, мэдээлэл хайх, олох боломж маш бага гэж хариулсан.
- Багш нар өөрсдийн сурлагаар хоцорсон хүүхэдтэй ажиллах арга барилаа “Сайн” гэж үнэлсэн байна.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ЗОРИЛТ 2: Зорилтот сургуулиудад нэгдүгээр ангийн хүүхдийн суралцах чадварыг дэмжих ялангуяа СӨБ-д хамрагдаагүй хүүхдэд сургуульд дасан зохицох, суралцах чадвар эзэмшихэд туслах бүтэц, тогтолцоо бүрдүүлэх

- Сургуулийн хүрээнд 1-р ангийн хүүхдэд чиглэсэн ажил нь ихэвчлэн багш-сургуулийн удирдлага, багш-эцэг эх хооронд л явагдаж байна.
- Сургууль болон орон нутгийн хамтрагч байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй, бэлтгэл хөтөлбөрийн цаг бага байгаа нь хүүхэд бүрт “Бэлтгэл хөтөлбөр”-ийг агуулгын дагуу үр дүнтэй олгох боломжийг багасгаж байна. Өмнөх хичээлийн жилүүдэд хэрэгжүүлж байсан 80 цагийн агуулгыг 60 цаг болгосон нь (агуулга нь адил боловч, цаг нь багассан) багш нарт ажлын ачааллыг бий болгож байна.

ЗОРИЛТ 3: Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх/ асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах

- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 78 хувь нь сургуулийн элсэлтийн талаарх мэдээллийг сургуулиас авч байсан байна. Сургуулиас зохион байгуулсан “Бэлтгэл хөтөлбөр”-ийн талаарх мэдээллийг эцэг эхчүүдийн 70 хувь нь авсан байна.
- Эцэг эхийн зөвлөл (ЭЭЗ)-өөс зохион байгуулж буй ажлууд дах эцэг эхийн оролцоо дутмаг байна. Нийт эцэг эхчүүдийн 3 хувь нь ЭЭЗ-өөс зохион байгуулсан аливаа үйл ажиллагаанд оролцоогүй байна.

- Эцэг эхчүүдийн дунд эцэг эхийн хурал, анги танхим тохижуулах зэрэг ажлуудад оролцоо өндөр байна. Гэвч ЭЭЗ-өөс сурлагаар хоцорч байгаа хүүхдийн хичээлийг давтуулах (37%), шинээр сургуульд орж байгаа хүүхдийн эцэг эхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх (54%) зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулахгүй байна гэжээ. Хэдийгээр оролцоо дутмаг байгаа ч, эцэг эхчүүдийн 77 хувь нь ЭЭЗ-өөс зохион байгуулж буй ажилд сэтгэл ханамжтай байна.

- Эцэг эхчүүдийн 96 хувь нь өөрсдийн хүүхдийн суралцах чадварыг бодитоор үнэлж чадна гэж хариулжээ. СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуульд анхлан орсон үеийн чадварыг “дунд”, одоогийн үнэлгээг “сайн” гэж үнэлсэн байна.

ЗОРИЛТ 4: Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах

- Хүүхдийн суралцах болон дасан зохицох чадварын хувьд СӨБ-д хамрагдсан, хамрагдаагүйгээс шалтгаалан ихээхэн зөрүү байгаа гэдгийг дүүргийн мэргэжилтнүүд бүгд хүлээн зөвшөөрч байлаа. Дүүргийн мэргэжилтнүүдийн хувьд бэлтгэл хөтөлбөрийн сургалтын агуулга нь сургуулийн орчинг танилцуулах, суралцах бэлтгэл ажлыг хангах зэргээр шинэчлэгдсээр байгаа нь давуу тал гэж үзэж байна.
- Дүүргийн боловсролын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар сургуулийн үйл ажиллагаанд дахь эцэг эхийн оролцоо бага, сургуулийн багш, ажилтнууд, эцэг эхийн хоорондын хамтын ажиллагаа сул байгаа нь хамгийн тулгамдсан асуудал болоод байна.

“БИЧИЛ УУРХАЙЧДЫН ШУДАРГААР ОЛБОРЛОСОН АЛТАН ЭДЛЭЛИЙГ ЗАХ ЗЭЭЛД ГАРГАХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ НЬ”



Захиалагч: Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Швейцарын хөгжлийн агентлаг (GIZ & SDC)

Судалгааны зорилго, зорилт

Төслийн үндсэн зорилго нь Монголын бичил уурхайчдын шударгаар стандартын дагуу олборлосон алтаар алтан эдлэл, гоёл чимэглэл хийн зах зээлд гаргах боломж, хэрэглэгчийн хүлээж авах хандлагыг тодорхойлох, цаашид маркетингийн нарийвчилсан судалгааг хийхэд шаардлагатай зах зээлийн үндсэн мэдээллийг боловсруулж захиалагч талд зөвлөмж өгөхөд оршино.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

**2015** ОНЫ
5 сараас**2015** ОНЫ
6 сар**181** МОНГОЛ
ХУДАЛДАН
АВАГЧИД**30** ГАДААДАД
АМЬДАРДАГ
МОНГОЛЧУУД**80** МОНГОЛД
АЖИЛЛАДАГ
ГАДААДЫН ИРГЭД**115** ЖУУЛЧИД

Эдгээрээс 52 ярилцлага нь онлайн судалгаагаар хийгдсэн.

Хэрэгцээ шаардлага

Монголын бичил уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийн чиглэлээр олон үр дүнгүүд гарсан.

Жижиг уул уурхайн салбарын үнэ цэнийг нэмэгдүүлэх нь ач холбогдолтой гэдгийг зарии үр дүнгүүд харуулдаг.

Үүнтэй холбогдуулан, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Швейцарын хөгжлийн агентлагууд нь Монголын бичил уурхайчдын шударгаар стандартын дагуу олборлосон алтаар алтан эдлэл, гоёл чимэглэл хийн зах зээлд гаргах боломж дээр төвлөрч байгаа билээ. Иймд бүтээгдэхүүний боломжийг судлах зорилгоор ИРИМ болон МИРИМ нь шударгаар алт олборлохын талаар алтан эдлэлийн талаар ойлголтын талаар олон төрлийн бүлгүүдээр шалгасан.

Арга зүй

Судалгаанд алтан эдлэл худалдан авагчдын талаар мэдээллийг цуглуулсан. Зорилтот түүврийг судалгаанд хамруулах үүднээс “Цасан бөмбөлөг”-ийн аргыг ашигласан. Энэхүү цасан бөмбөлийн арга нь зөвхөн Монгол алтан эдлэл хэрэглэгчид болох өндөр орлоготой, Монгол болон Гадаадад амьдардаг хэрэглэгчдийг илрүүлэхэд ашигласан гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй.

Судалгаанд дараах үйл ажиллагааг хамруулсан:

- өмнөх судалгааны баримт бичгийн судалгаа
- арга зүй болон судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах
- туршилт судалгаа
- цахим хэлбэрээр болон цаасан байдлаар авах судалгаа

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСАГТ БИЧИЛ УУРХАЙГААС ОРУУЛЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: СУУРЬ СУДАЛГАА




Захиалагч Тогтвортой бичил уурхай төсөл, Швейцарын хөгжлийн агентлаг

Судалгааны зорилго, зорилт

Суурь судалгааны үндсэн зорилт нь бичил болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын зүгээс орон нутгийн (аймаг) эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэхэд оршино

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Зорилтот 6 аймаг: Төв, Сэлэнгэ, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Баянхонгор



2015 ОНЫ
7 сараас

2015 ОНЫ
9 сар



196 ЯРИЛЦЛАГА



29 БАРИМТ БИЧИГТ СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Швейцарын Хөгжлийн Агентлагийн хэрэгжүүлж буй Тогтвортой бичил уурхай төсөл анх 2005 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2015-2018 онд тус төслийн 4 дүгээр үе шат явагдах юм. Тогтвортой бичил уурхай төслийн нийтлэг зорилго нь Монгол улсад эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан бичил уурхайн салбарыг бий болгож, дэлхий нийтийн хэмжээний гар аргаар болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тэргүүлэх туршлагауудыг нэвтрүүлэн үр шимийг нь хүртэх, хувь нэмэр оруулах явдал юм. Энэхүү судалгаа нь дээрх төслийн суурь судалгаа болох юм.

Арга зүй

Бичил уурхайчид болон ченжүүдийн орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцохдоо дараах аргаар бүрэн нөлөөллийг тооцоолсон.

Шүүд нийлэгжилт - бичил уурхайчид, ченж	Шүүд бүс нийлэгжилт - ЖДБ эрдэмт малчид	Дүн нийлэгжилт - эхлэлт, татвар, хувиар, хувьд уурхайчид, ченж
Ажил эрхлэлт Ажлын байр, цагын		Бичил уурхайч, ченж бие эдийн засгийн, өөрөө өөрсөд
Татвар, хувиар Татвар, хувиар, нийгмийн даатгал, эдийн засгийн даатгал, сонголт	ЖДБ ажил эрхлэлт ажлаагийн төс, цагын ажил	Зөвгөөрөө гүйцэтгэх БГ, ченжээс бүтээгдсэн өөрчлөгөөс төсөв, өөрчлө
Хувьцаан авалт Эдийн засгийн зөвхөн зөвхөн	ЖДБ татвар, хувиар татвар, хувиар, даатгалууд	Малчид бие Эдийн засгийн
Олон нийтийн үзэвэг оруулалт Нийгэм, эдийн засгийн, эдийн засгийн	Малчид ажил эрхлэлт БГ өөрчлөх буй өөрчлө	

Уг тооцооллыг хийхдээ бичил уурхайчид, ченжүүд, орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид, малчдын орлого, зарлага, татвар төлөлт, хөрөнгө оруулалтыг нарийвчлан асууж тодруулсан. Мөн орон нутгийн засаг захиргааны болон ТББ-ын баримт бичиг, статистик тоо мэдээг ашигласан.

Үр дүн

Бичил уурхайчид болон ченжийн орон нутгийн эдийн засгийн хувь нэмрийг эдийн засгийн үржүүлхийн аргаар тооцсон.

Бичил уурхайчид болон ченж нарын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд, шууд бус, дам нөлөөллийг дараах байдлаар тооцоолон бодов.

Судалгаанд тулгарсан нэг гол хязгаарлалт нь төсвийн хомсдлоос үүдэлтэйгээр судалгаанд хамрагдах хүмүүсийн түүвэрлэлт дээр тэднийг бүрэн төлөөлөхүйц түүврийн хэмжээ хязгаартай байсны улмаас цуглуулсан мэдээллийн ихэнх нь ТББ-ууд болон төрийн байгууллагуудын гарган өгсөн мэдээлэлд үндэслэгдсэн явдал юм. ТББ-уудын цуглуулсан мэдээллийн хэмжээ, чанар нь сумдаас хамааран ихээхэн ялгаатай байв. Түүнчлэн орон нутгийн төрийн байгууллагууд нь бичил уурхайтай холбоотой орлого, зарлагаа дэлгэрэнгүй задаргаатай бүртгэдэггүй тул энэ талаар мэдээлэл цуглуулах боломжгүй байв. Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд ашигласан мэдээллийн ихэнх хэсгийг ТББ-уудаас цуглуулсан бөгөөд цаашид хийгдэх судалгаанд орон нутгийн төрийн байгууллагуудын ажилтнуудыг илүүтэй татан оруулж, мэдээлэл цуглуулах шаардлагатай.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Доорхи хүснэгтэд харуулсан мэдээлэл нь бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутгийн эдийн засагт (сумын түвшний) үзүүлж буй хувь нэмэр болон үржигдэх нөлөөллийг нь харуулсан. Хүснэгт 1 дээр үзүүлсэн мэдээллийг сар тутмын байдлаар харуулсан.

Нийт Эдийн засгийн болон үржүүлэхийн нөлөөлөл - Сумдын түвшинд

Байршил		Нийт эдийн засгийн нөлөөлөл тогрог/сар			Үржүүлэх			
Аймаг	Сум	Шууд нөлөөлөл	Шууд бус нөлөөлөл	Дам нөлөөлөл	Шууд	Шууд бус	Дам нөлөөлөл	Нийт
Баянхонгор	Баян-Овоо	676,233,660	630,000	198,174,968	1	0.001	0.293	1.294
	Бөмбөгөр	1,259,449,330	380,238	250,277,517	1	0.000	0.199	1.199
Говь-Алтай	Есенбулаг	1,842,947,368	20,742,019	210,288,400	1	0.011	0.114	1.125
	Бигэр	Na	1,030,625	62,891,752	1	Na	Na	Na
Дорноговь	Айраг	253,377,201	6,977,857	76,060,534	1	0.028	0.300	1.328
Дундговь	Хулд	577,582,836	9,673,769	114,564,733	1	0.017	0.198	1.215
	Өлзийт	463,954,546	1,177,193	161,902,533	1	0.003	0.349	1.351
Сэлэнгэ	Мандал	337,493,576	144,900,350	113,387,917	1	0.429	0.336	1.765
	Шарын гол	1,829,290,604	5,366,660	152,115,122	1	0.003	0.083	1.086
	Орхонтуул	342,049,200	5,623,200	36,343,971	1	0.016	0.106	1.123
Төв	Заамар	410,077,345	4,513,596	81,633,904	1	0.011	0.199	1.210
	Борнуур	106,758,000	6,085,310	67,287,171	1	0.057	0.630	1.687
Нийт дүн		8,099,213,666	207,100,817	1,326,753,554	1	0.026	0.164	1.189

- Сумын түвшинд үзүүлж буй нийт шууд нөлөөлөл нь 8,099,213,666 төгрөг байв. Үүнд олон нийтийн үйл ажиллагаанд зориулан хөрөнгө оруулалт хийсэн 801, 857, 000 төгрөгийг (капитал хөрөнгө оруулалт) оруулан тооцоогүй. Энэхүү хөрөнгө оруулалтыг сар тутмын байдлаар тооцон гаргах боломжгүй учир нь бүхий л хөрөнгө оруулалт нь тухайн оролцогчийн үйл ажиллагааны бүхий л он жилүүдэд хийгдсэн байдаг.
- Сумын түвшин дэхь нийт шууд бус нөлөөлөл нь сард 207,100,817 төгрөг байна.
- Бичил уурхайчид, малчдын зүгээс сумын хэмжээнд үзүүлж буй нийт дам нөлөөлөл нь сард 1,326,753,554 төгрөг байна. Энэхүү тооцоонд малчдыг багтаасан шалтгаан нь ихэнх тохиолдолд малчид ч мөн гар аргаар ашигт малтмал олборлож, нэмэлт орлого олдогтой холбоотой.
- Бичил уурхайчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй үржигдэх нөлөө 1.189 байна.



“БАРОМЕТРИЙН СУДАЛГАА 2015” СУДАЛГАА



Захиалагч

Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв

Судалгааны зорилго, зорилт

Ойрын нэг жилийн хугацаанд /2016.01-2016.12/ хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байх ажиллах хүчнийг мэргэжил, салбар, байршил бүрээр тодорхойлох судалгааны мэдээллийг цуглуулах.

- Судалгааны мэдээллийг 2014 оны Бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа /захиалагчаас санал болгосон/ ААНБ-аас цуглуулах
- ААНБ-уудыг эдийн засгийн салбараар жигд хамруулах
- Мэдээлэл цуглуулалтыг сонгосон түүврийн дагуу, алдагдал багатай гүйцэтгэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

“Барометрийн судалгаа 2015” судалгааны мэдээлэл цуглуулах, зориулалтын програмд шивж оруулах судалгааны төсөл нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төв, хөдөөгийн 148 сумыг хамарч хийгдсэн. Улаанбаатар хотод 1300, хөдөө орон нутагт 745, нийт 2050 ААНБ-аас судалгааны мэдээлэл цуглуулсан.



2015 ОНЫ
6 сараас

2015 ОНЫ
10 сар



2050 АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Манай улсын хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлтийг судалж тодорхойлох нэг судалгаа нь Хөдөлмөрийн яамнаас жил бүр гүйцэтгэдэг Барометрийн судалгаа юм. Тус судалгаа нь хөдөлмөрийн эрэлтийг ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн салбар, хэрэгцээт ажиллах хүчний тоо, газарзүйн байршил, ажлын байрны хэлбэр, эрэлт бий болох хугацаа зэргээр тодорхойл нарийвчлан тодорхойлдог.

Барометрийн судалгааны үр дүнг салбарын бодлого боловсруулагч нар бодлого боловсруулахдаа, боловсролын салбар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын байгууллагууд элсэлтийн бодлого тодорхойлохдоо, түүнчлэн хувь хүн мэргэжилээ сонгохдоо тус тус ашиглах боломжтой юм. Мөн хөдөлмөрийн зах зээлийн ажил мэргэжлийн эрэлтийг боловсролын салбарын мэргэжлийн нийлүүлэлттэй харьцуулсан шинжилгээ хийх зэрэг бусад судалгаа, шинжилгээний ажилд мөн суурь мэдээлэл болгон ашиглах боломжтой юм.

Арга зүй

Барометрийн судалгаа нь жил бүр давтагдах түүвэр (cross section) судалгаа юм. Судалгаанд оролцогч нь эдийн засгийн үйл ажиллганы салбар, ажилчдын тооны бүлгийг түлхүүр үзүүлэлт болгон түүвэрлэсэн ААНБ-ууд байна. Судалгааны мэдээллийг байгууллагын үндсэн мэдээлэл болон ажил олгогчийн хүлээлтийг тодорхойлох 42 асуулт бүхий анкетаар цуглуулсан.

Мэдээлэл цуглуулалтын онцлог

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн. Талбарт зочлохын өмнөх аж ахуйн нэгжүүдтэй утсаар холбогдох, байгууллагуудын цахим хуудас, лавлах, төрийн байгууллагын бүртгэл зэргээс хаягийн мэдээллийг тодруулсан.

Захиалагч буюу Хөдөлмөрийн яамнаас санал болгосон, хэвийн үйл ажиллагаатай аж ахуйн нэгжүүдээс мэдээллийг цуглуулсан. Судалгааны үр дүн хазайлтгүй, үнэн зөв гарах нэг чухал нөхцөл нь мэдээлэл цуглуулахдаа санамсаргүй түүвэрлэн сонгосон тэр дарааллыг чанд баримтлах явдал юм. Бид энэхүү мэдээлэл цуглуулалтыг уг шаардлагын дагуу гүйцэтгэсэн.

Судалгааны асуудлын онцлогтой холбоотойгоор тухайн байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудаас асуулгын маягтаар мэдээлэл цуглуулсан. Мэдээлэл цуглуулалтыг таблет ашиглан гүйцэтгэсэн.

Цуглуулсан тоон мэдээлэлд Хөдөлмөрийн яамны хийсэн боловсруулалт, шинжилгээний үр дүнг нэгтгэсэн дэлгэрэнгүй тайланг www.hudulmug.mn цахим хуудаснаас үзэж танилцана уу



“НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ШУДАРГА БАЙДАЛ, ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ”



Захиалагч


Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар

Судалгааны зорилго, зорилт

Нийслэлийн Нутгийн Захиргааны байгууллагын шийдвэрүүд нь иргэдийн эрх ашиг, сонирхолд нийцэж буй эсэх, нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнуудын шударга байдал, шийдвэрийн ил тод, нээлттэй байдалд эрсдэлийн үнэлгээ хийх, зөрчилтэй шийдвэрүүдийг тодорхойлох, зөрчлийг арилгах талаар зөвлөмж хүргүүлэх юм. Үнэлгээ нь дараах 5 зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. ННЗБ-уудын шийдвэр нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан ил тод байдлыг хангасан эсэх,
2. ННЗБ-с гарсан шийдвэр нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын дагуу боловсруулж баталсан эсэх,
3. Төрийн байгууллага, албан тушаалтнуудын шударга байдал, шийдвэрийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг нийслэлийн Засаг даргын 2012 оны “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарчим, арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж, Авилгатай тэмцэх газрын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх аргачлал”-ын дагуу хийх,
4. Шийдвэр нь иргэдийн эрх ашгийг хөндсөн эсэх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, эрсдэл учирсан болон учирч болохуйц нөхцөл байдлыг тогтоох,
5. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан нь үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх дүгнэлт.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



2015 ОНЫ
7 сараас

2015 ОНЫ
11 сар



420 АСУУМЖ



49 ЯРИЛЦЛАГА



61 ШИЙДВЭРТ ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ



19 ЦАХИМ ХУУДАСТ ШИНЖИЛГЭЭ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Арга зүй

Судалгаанд дэвшүүлсэн олон төрлийн зорилгод хүрэх үүднээс дараах арга, аргачлалуудыг ашиглав.

- Төрийн үйлчилгээ авсан 420 иргэнээс АТГ-ын Төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх аргачлал дагуу асуумж судалгаа авсан
- Нийслэлийн нутгийн захиргааны 19 байгууллагын 49 албан тушаалтантай ярилцлага хийсэн
- ИРИМ-ийн 2010 онд өөрсдийн боловсруулан ашиглаж буй цахим хуудасны мониторингийн аргачлалыг ашигласан
- Нийслэлийн нутгийн захиргааны 19 байгууллагаас гаргасан 61 захирамж шийдвэрт хууль зүйн шинжилгээ хийсэн

Үр дүн

Мэдээллийн ил тод байдал ба эрсдэл

ННЗБ-уудын ил тод байдлын үнэлгээг бид цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, мэдээллийн ил тод байдал, хүртээмжтэй байдалд өгсөн иргэдийн үнэлгээгээр төлөөлүүлэн хэмжлээ.

ННЗБ-уудын цахим хуудасны ил тод байдлын дундаж үнэлгээ нь 45,1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13,4 хувиар өссөн үзүүлэлт юм.

ННЗБ-уудаас хамгийн өндөр үзүүлэлтийг ХУД-ийн ЗДТГ үзүүлж 65,8 хувийн үнэлгээ авсан нь өнгөрсөн оны үзүүлэлтээсээ даруй 45,7 хувиар өссөн үзүүлэлт байна.

ННЗБ-уудын хувьд худалдан авах ажиллагааны тухай мэдээлэл хамгийн муу үнэлгээг (37,8%) авсан байна.

ННЗБ-уудаас гаргаж буй шийдвэрийн ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээ нь 38,6 хувь нь сайн, 37,9 хувь нь дунд, 23,5 муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Иргэд мэдээллийн ил тод байдалд харьцангуй сайн үнэлгээ өгсөн ч 43,6 хувь нь эдгээр байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар огт мэдээлэл авдаггүй гэж хариулсан байна

Иргэдэд мэдээлэл түгээхэд цахим хуудас (35%), мэдээллийн самбар (15%), төрийн байгууллагын ажилтан (25%) зэрэг нь хүртээмж муутай эх сурвалж байгаа нь бас нэг эрсдэлийг бий болгож байна. Иргэдэд мэдээлэл түгээх хамгийн хүртээмжтэй хэрэгсэл нь телевиз (60%) байна. Иймээс мэдээллийг хүртээмжийг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулах үүднээс ННЗБ-ууд нь телевиз болон бусад ОНМХ-ээр мэдээлэл түгээх ажлыг нэмэгдүүлбэл зохино.

ННЗБ-уудын шударга байдлын үнэлгээ

ННЗБ-уудын шударга байдлын түвшинг АТГ-ын даргын 2010 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх аргачлал”-д үндэслэн үнэлсэн. Энэхүү аргачлал нь иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг үнэлэх зорилготой тул түүвэрт хамрагдсан 19 байгууллагыг энэ аргачлалаар үнэлэх боломжгүй юм. Харин зөвхөн иргэдэд үйлчилгээ үзүүлж буй 14 байгууллагыг энэхүү аргачлалаар үнэлэхийг зорилоо.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүснэгт 1 ННЗБ-уудын хариуцлагатай, ил тод, шударга байдлын түвшин, байгууллага тус бүрээр

№	Хариуцлагатай байдлын түвшин	Ил тод байдлын түвшин	Шударга байдлын түвшин	
1	Төрийн байгууллагын 2014 оны дундаж	3.54	3.3	3.43
2	ННЗБ-ууд	3.3	3.12	3.21
3	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	3.06	2.86	2.96
4	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	3.42	3.02	3.2
5	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	3.24	3.06	3.15
6	Хан-Уул дүүргийн ЗДТГ	3.38	3.27	3.32
7	Налайх дүүргийн ЗДТГ	3.02	3	3
8	Баянзүрх дүүргийн ЗДТГ	3.17	2.89	3.03
9	Баянгол дүүргийн ЗДТГ	3.24	3.15	3.19
10	Багахангай дүүргийн ЗДТГ	3.38	3.16	3.27
11	Багануур дүүргийн ЗДТГ	3.15	3.15	3.14
12	Нийслэлийн Тээврийн газар	3.71	3.47	3.59
13	Нийслэлийн Өмчийн Харилцааны газар	3.89	2.76	2.82
14	Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний газар	3.29	3.15	3.22
15	Нийслэлийн Боловсролын газар	3.59	3.54	3.57
16	Нийслэлийн Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн газар	3.53	3.23	3.39

Хариуцлагатай болон ил тод байдлын үзүүлэлтэд үндэслэн тооцсон ННЗБ-уудын шударга байдлын дундаж түвшин 3.21 буюу 2014 оны төрийн байгууллагуудын дундаж үнэлгээнээс 0.22 пунктээр бага байна.

ННЗБ-уудын шударга байдлын түвшинг дээшлүүлэхийн тулд доорх үзүүлэлтүүдийг сайжруулах зайлшгүй шаардлага байна:

1. Төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээлэл нээлттэй ил тод байх;
2. Тухайн байгууллагын албан хаагчдын мэдээлэл ил тод нээлттэй байх;
3. Хариуцлага тооцох механизм хэрэгждэг байх;
4. Төрийн үйлчилгээг боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог байдал.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2015



Захиалагч: IRIM судалгааны хүрээлэн

Судалгааны зорилго, зорилт

Энэ судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд доорх зорилтууд тавьсан:

1. Өнгөрсөн удаагийн мониторингийн арга зүйг зарчмын хувьд баримтлах. Ингэх нь харьцуулагдахуйц байдлыг хадгална. Гэхдээ үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх
2. Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
3. Мониторингийн үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
4. Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;

Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Улсын хэмжээний 85 төрийн байгууллагын цахим хуудасны мэдээлэл цуглуулсан. Үүнд:

- Монгол улсын яам -15;
- Хэрэгжүүлэгч агентлаг - 19
- Тохируулагч агентлаг -10;
- Аймгуудын захиргаа- 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллага -9 хамрагдсан.

Хэрэгцээ шаардлага

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ” нь анх “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” ЗГ-ын 143 дугаар тогтоол хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, дүгнэх зорилгоор 2010 онд IRIM судалгааны хүрээлэн Авилгатай Тэмцэх Газрын (АТГ) захиалга, UNDP-ийн санхүүжилттэйгээр эхэлсэн. Энэ ажлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор АТГ-тай хамтран судалгааны үр дүнг танилцуулах хэд хэдэн уулзалт зохион байгуулсан. Үүнийг

үргэлжлүүлэн хийх шаардлагаар 2014 оноос IRIM хүрээлэн өөрсдийн санхүүжилтээр, албан ёсны зөвшөөрөлтэй гүйцэтгэж байна.

Арга зүй

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсуудыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж жагсаалт гаргах нь мониторингийн нэг зорилт юм. Үүний тулд үндсэн гурван шинжилгээг хийсэн:

1. Тухайн үзүүлэлтийн хэрэгжилт цахим хуудсуудад ямар түвшинд байгааг хэмжүүр тус бүрээр хувь тооцож үнэлэх



2015 ОНЫ
6 сараас

2015 ОНЫ
8 сар



15 ЯАМ

19 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ

21 АЙМГИЙН
ЗАХИРГАА

10 ТОХИРУУЛАГЧ
АГЕНТЛАГ

11 НИЙСЛЭЛ
ДҮҮРГИЙН ЗАХИРГАА

9 УИХ БОЛОН ТҮҮНИЙ
ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

2. Өмнөх судалгаатай харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах
3. Байгууллага тус бүрийн үзүүлэлтүүдээс авсан оноо, хувийг эрэмбэлж, хавсралтад харуулах

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн ач холбогдлыг ялгаатай байдлаар тогтоосон. Үүнийг дараах дүрсэд харуулав.



Ил тод байдлын хэмихдээ дараах шкалын дагуу үнэлгээ гаргасан.

Хувь	Ил тод байдал
81-100	Бүрэн ил тод
61-80	Ил тод
41-60	Зарим талаар ил тод
0-40	Хаалттай

Үр дүн

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал нь 2014 онд дунджаар “хаалттай” гэсэн ангилалд багтаж байсан бол 2015 онд “зарим талаар ил тод” гэсэн ангилалд шилжиж байна. Төрийн байгууллагын цахим хуудаснуудаас хамгийн өндөр үнэлгээг яамдын цахим хуудас авсан ба өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 22 нэгж хувиар үзүүлэлтүүд нь сайжирчээ. Аймаг, нийслэлийн болон парламентийн байгууллагуудын цахим хуудасны үнэлгээ 40 хувиас дээш буюу “зарим талаар ил тод” гэсэн ангилалд орж байгаа бол бусад байгууллагын үзүүлэлт “хаалттай” гэсэн ангиллаас гараагүй хэвээр байна.



Төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал бүх шалгуурын хувьд нэмэгдсэний дотор мэдээллийн найдвартай байдал бусдаа илүү нэмэгджээ.



Төрийн байгууллагууд өөрийн үйл ажиллагаатай хамааралтай мэдээллийг цахим хуудасандаа нийтэлдэг байдал 2014 онд 40,8 хувьтай байсан бол 2015 онд 56,4 хувьтай болон өсчээ.

Мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтүүд 2014 онд 13,9 хувьтай маш хангалтгүй үр дүнтэй байсан бол 2015 оны судалгаагаар 47,1 хувь болон эрс өсчээ.

Дээрх төрийн байгууллагуудаас аймаг, нийслэлийн болон парламентийн байгууллагуудын хувь 40 хувиас дээш буюу “зарим талаар ил тод” гэсэн ангилалд орж байгаа бол бусад байгууллагуудын үзүүлэлт хэдийгээр өсөлттэй байгаа ч “хаалттай” гэсэн ангиллаас гараагүй хэвээр байна.

Мэдээллийн хүртээмжтэй байдлын хувь 43,5 хувь болсон нь өмнөх оны үр дүнтэй харьцуулж үзэхэд бага зэргийн өсөлттэй байдлыг харуулж байна.

Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт 75,7 хувьтай байгаа нь эерэг үр дүн болж байна.



“ХӨДӨӨГИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ




Захиалагч: Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгаа нь МУЗН-ийн Халамжийн хөтөлбөрөөс 2012-2015 онд хэрэгжүүлсэн ХНХТ-ийн төслийн эцсийн үнэлгээг хийх зорилготой. Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Төслийн шууд үр шим хүртэгчдэд үзүүлсэн нөлөөллийг илрүүлэх
- Төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх
- Төслийн үйл ажиллагаа зорилго, шалгуур үзүүлэлтээ хэр хангасныг тодорхойлох

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ: Тус үнэлгээний ажил Хөвсгөл, Орхон, Өвөрхангай аймгуудад хэрэгжсэн.



2015 ОНЫ
7 сараас

2015 ОНЫ
9 сар



300 АСУУМЖ



13 ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 1-р тэргүүлэх чиглэлийн хүрээнд МУЗН-ийн Халамжийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн “Хөдөөгийн нийгмийн халамжийн” төслийг 2013-2015 оны хооронд зорилтот 7 аймагт хэрэгжүүлсэн. Төсөл нь үндсэн гурван зорилготой бөгөөд зорилго тус бүр нь хөдөөгийн нийгэм-эдийн засгийг сайжруулах, нэн эмзэг бүлгийг нийгмийн халамжийн хөтөлбөрт хамруулах зэрэг нийт 16 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Арга зүй

Төслийн хэрэгжилт, үр дүнг үнэлэхдээ

- Төлөөлөхүйц түүвэр – Эх олонлогийг төлөөлөхүйц байдлаар түүвэр судалгаанд оролцогчдыг сонгосон. (Итгэх түвшин 95 хувь, итгэх завсар 5 хувиар тооцсон.)
- Үр шим хүртэгчид ба төслийн хэрэгжүүлэгч талуудын байр суурийг чанарын болон тоон судалгааны аргаар мэдээлэл цуглуулж харьцуулан үнэлсэн.
- Харьцуулагдахуйц байх – Төслийн суурь судалгааны үр дүнд анхаарал хандуулж, төслийн хэрэгжилт, үнэлгээ, санал дүгнэлтийг хийхдээ харьцуулан авч үзсэн.

Баримт бичгийн судалгаа, асуумж, бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага зэрэг аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан.

Судалгаагаар нийт 300 респондентоос анхдагч мэдээлэл цуглуулж, 13 ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Үр дүн

- Тоон болон чанарын судалгааны үр дүнг харахад, төслийн хүлээгдэж буй үр

дүнгүүд 100% амжилттай биелсэн байна. Тухайлбал, төслийн 16 үйл ажиллагааны 4 нь буюу амьдрах ухааны сургалт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл олгох, материаллаг туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах зэрэг үйл ажиллагаа төлөвлөсөн үзүүлэлтээс давж биелсэн. Орон нутагт ХӨ-өөр нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх зорилт хангагдаж, аймгуудад төлөвлөгдсөн тоогоор ХӨ амжилттай ажиллаж байна.

- ДШХ нь эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн халамжийн үйл ажиллагааны туршлагатай болсон байна. Зорилтот бүлгийн хамгийн их тулгамдсан асуудлыг шийдэж чадсан үйл ажиллагаа нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суугч, нэн эмзэг бүлгийн хүмүүст бичиг баримттай болгон эрүүл мэндийн үйлчилгээ авах, тэтгэмж, тэтгэвэрт хамруулах зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхийг бий болгосон үйл ажиллагаа юм. Төслийн халамжлуулагчдын нийгмийн идэвх оролцоо сайжирч, гэр бүлдээ болон нийгэмдээ эерэг хандлагатай болж нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үр дүнд хүрсэн байна.
- Төслийн хэрэгжилтийн явцад орон нутгийн төрийн болон бусад байгууллагын идэвх оролцоо өндөр байж, олон талаар хамтран ажилласан нь төсөл амжилттай хэрэгжихэд эерэг нөлөөг үзүүлжээ. Төслийн явцад мэргэжлийн болон амьдрах ухааны сургалтууд төслийн үр шим хүртэгчдэд ихээхэн үр дүнтэй байсан ажээ. Мөн халамжлуулагчдад чиглэсэн сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд олон байгууллага хамтран ажиллажээ.
- Төслийг хэрэгжүүлсэнээр МУЗН-ийн талаархи иргэдийн эерэг ойлголт, хандлага нэмэгдсэн байна. Төслийн үр шим хүртэгчид төслийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чанар, зохион байгуулалт, эргэх холбоо, үр дүн, төслийн багийн

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ажилчдын үр чадварыг сайн /99%/ гэж үнэлж байна. Төслийн үр шим хүртэгчдэд үзүүлсэн материаллаг тусламж /хүнс, эрүүл ахуйн бараа, гэр, ХБИ-ийн туслах хэрэгсэл/-ийн бараа бүтээгдэхүүнийг чанартай, хэрэгцээг нь хангасан, амьдралд хэрэгтэй үед бодитой хувь нэмэр болсон гэж /90%/ сайнаар үнэлсэн.

- Сургалтуудын хэрэгцээнд нийцсэн байдал, зохион байгуулалт, сургагч багшийн чадвар, сургалтын хэрэглэгдэхүүн болон чанар, үр нөлөөг хамрагдсан үр шим хүртэгчид нь өндрөөр /90%-ээс дээш хувь/ үнэлсэн.
- Төсөл хэрэгжсэн аймгуудад эмзэг бүлгийн иргэд олон, тэдэнд чиглэсэн нийгмийн халамжийн үйл ажиллагааны хамрах хүрээ бага байдаг тул энэ нийгмийн халамжийн төсөлд дахин хамрагдах сонирхолтой иргэд их байна. Нөгөө талаас төслийг хэрэгжүүлэх гол нэгж болох СДИ-ийн тогтвортой сүлжээ бий болж, эдгээр идэвхтнүүд сайн дураар үргэлжүүлэн ажиллах хүсэлтэй байна
- Төслийн хүрээнд тогтвортой хүний нөөц, нийгмийн халамжийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх сайн туршлагауд бий болсон байна. Тухайлбал төслийн үйл ажиллагааг аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт оруулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах, холбогдох байгууллагуудтай хамтран эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, сайн дурын идэвхтнүүдийг хэсгийн ахлагчтай хамт ажиллуулах зэрэг ажлууд хийгдэж байна.
- Төслийн санхүүжилт зогссон ч ХӨ, СДИ-ээр дамжуулан хүргэх гэрийн эргэлт, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажил, эрүүл

мэнд, амьдрах ухааны сургалтуудуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой байна. Зорилтот аймгуудад төслийн ийн үр дүнд бий болгосон хамтын ажиллагаа, эд материалын нөөц дээрээ тулгуурлан цаашид тогтвортой авч үлдэх амжилттай туршлагауд бий болсон байна. Орон нутгийн удирдлагуудын хувьд ХНХТ-ийн зарим үйл ажиллагааг цаашид тогтвортой авч үлдэх шинэ санал санаачилгыг гаргаж байна.

Санал зөвлөмж

- Ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллаж зарим санхүүжилт, зохих тусламж дэмжлэгийг авч төслийн үр нөлөө, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх
- Төсөл хэрэгжиж буй аймаг орон нутгийн Дунд Шатны Хороо (ДШХ)-ын ажилчдын дунд мэдээ мэдээлэл, туршлага солилцох үйл ажиллагааг тогтмол хийх
- Гэрээр эргэх болон Халамж өргөө (ХӨ)-ний үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх
- Төсөл нь тухайн орон нутгийн нэн эмзэг бүлгийнхэнд бага хүрсэн тул цаашид төслийн цар хүрээг тэлж, үр шим хүртэгч нарыг олноор хамруулах
- Төслөөс хэрэгжүүлж байсан мэргэжлийн сургалтад залуучуудыг өргөнөөр хамруулах
- Сайн дурын идэвхитэн (СДИ)-ий үйл ажиллагааг эрчимжүүлэхийн тулд шагнал урамшуулал тогтмол олгох, үйлчилгээ явуулах зардлыг нөхөн олгох, аюулгүй байдлыг нь маш сайн хангах



МОНГОЛЫН ХҮНСНИЙ НОГОО, МАЛ АЖ АХУЙ, НЭХМЭЛИЙН САЛБАРЫН САЙН ТУРШЛАГЫН СУДАЛГАА



Захиалагч: Европын холбоо, 'GFA consulting' Олон улсын байгууллага

Хамтрагч Технологийн дээд сургууль, Бүсийн арга зүйн төвүүд, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо.

Судалгааны зорилго, зорилт


Энэхүү судалгаа нь гурван жил үргэлжлэх олон үе шаттай төслийн эхний үйл ажиллагаа юм. Судалгаагаар цуглуулсан баримт мэдээ, тэдгээрийн бүтэц, найдвартай байдлаас төслийн дараа дараагийн үйл ажиллагаанууд болон төслийн үр дүнгүүд хамаарна. Судалгааны гол зорилго нь:

1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ
2. Техник, мэргэжлийн боловсролын сургалтын хэрэгцээ шаардлага ба бэрхшээл
3. ТМБС-ын сайн туршлагуудыг илрүүлэхэд оршино.

Сайн туршлага гэдэгт ТМБС-ын тогтолцооны үр дүнг дээшлүүлэх, мэргэжил, ур чадварыг ахиулах, ажлын байр бий болгох, сургалт болон давтан сургалтыг сайжруулах бүх үйл ажиллагааг хамруулсан.

Эхний хоёр сэдвийн хүрээнд цуглуулсан мэдээлэл нь сайн туршлагуудыг үнэлж, сонгоход хэрэглэгдэх "Анхдагч мэдээлэл" бөгөөд дараа нь тэргүүн туршлагуудын жагсаалт (түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх туршлагуудыг захиалагч сонгох) гаргахад мөн хэрэглэгдэнэ. Эдгээр "анхдагч мэдээлэл"-д үндэслэн тэргүүн туршлагуудын каталоги бэлтгэх юм.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ:

Монголын хүнсний ногоо, мал аж ахуй, нэхмэлийн салбарын сайн туршлагыг илрүүлэх судалгаа нь Улаанбаатар хот, Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймаг, Баруун болон Говийн бүсийг хамарсан.



2015 ОНЫ
9 сараас

2016 ОНЫ
2 сар



1212 АСУУМЖ



43 ЯРИЛЦЛАГА



8 БАРИМТ БИЧИГТ СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Монгол улсын иргэдийн дөрөвний нэг нь ядуу амьдарч байгаа бөгөөд ядуурлын гол шалтгаан нь ажилгүйдэл юм. Гэтэл залуучуудын гуравны нэг нь ажилгүй байгаа ба үр чадвар дутмаг хэмээгдэж байна. Хэдийгээр тогтвортой өсөлтийг хангахад тулгамдаж буй асуудлууд их байгаа боловч залуучуудад боломж их байна. Тухайлбал, үр чадвартай мэргэжилтэний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдсээр байгаа юм. Иймээс Европын Холбоо Монгол улсын Засгийн Газрын хүсэлтийг хүлээн авч, өөрчлөгдөн буй эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн Мэргэжлийн боловсролын сургалтыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж бай байна.

Арга зүй

Судалгаагаар зорилтот 3 салбарын хүрээнд дараах нэмүү өртгийн хэлхээний загварыг боловсрууллаа. Үүнд:

- Мах, махан бүтээгдэхүүний нэмүү өртгийн гинжин хэлхээ
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн гинжин хэлхээ
- Сүлжмэлийн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн гинжин хэлхээ
- Төмс, хүсний ногоо үйлдвэрлэлийн (талбайн болон хүлэмжийн) нэмүү өртгийн гинжин хэлхээ

Судалгаанд оролцогчид нийт 343 сайн туршлага санал болгосон. Шалгуурын дагуу 3 салбарын 215 туршлагыг 'сайн туршлага' гэж үзсэн.

Үр дүн

- Ажиллах хүчний түүвэр судалгаанаас үзэхэд, зорилтот гурван салбарын ажиллагсдын дийлэнх нь түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалтын дамжлагад ажиллаж байна. МАА-н салбарын 99%, нэхмэлийн салбарын 97%-д нь малчид үйлдвэрлэлийн процесст оролцож байна. Харин хүнсний ногооны салбарын үйлдвэрлэлийн 83%-д фермерүүд оролцож байна.
- 2013, 2014 онуудад хүнсний ногоо таригч, түүгч, хүнсний технологич, оёдолчин, сүлжигч, кительчин зэрэг ажил мэргэжлүүд эрэлт өндөртэй, ажиллах хүчний дутагдалтай байсан. Анхдагч судалгаагаар ч дээрх мэргэжлүүд салбар тус бүртээ мөн эрэлт өндөртэй байлаа.
- Хөдөөгийн бичил бизнес эрхлэгчдийн 39.3% нь МСҮТ төгсөгчдийг ажилд авах сонирхолтой байна. Ажилчдаа мэргэжлийн үр чадвар ахиулах (41.5%), тоног төхөөрөмж ажиллуулах үр чадвар (29.5%), багаар ажиллах чадвар ахиулах (23.7%) сургалтуудыг авах хэрэгцээ байна.

Судалгааны ирээдүйн ач холбогдол

Тус судалгаа нь зөвхөн зорилтот гурван салбарын сайн туршлагаудыг судлаад зогсоогүй малчид, бичил бизнес эрхлэгчид, ажилгүйчүүд зэргийг хамруулсан ажил эрхлэлт, хүндрэл бэрхшээл, ажил мэргэжлийн эрэлт болон нийлүүлэлтийг судалсан цогц судалгаа болсон. Иймээс бусад олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй ижил төстэй төслүүд болон Монгол дахь Мэргэжлийн боловсролыг хөгжүүлэхээр ажиллаж буй сонирхогч талууд тус судалгааг ашиглах боломжтой юм.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ ТОСӨЛ: МОНГОЛ УЛСЫН АТГ-ЫН ҮНЭЛГЭЭ



Захиалагч Трансперенси Интернэшнл
Үнэлгээний зорилго, зорилт

Үнэлгээний хүрээнд дараах үндсэн 3 зорилгыг дэвшүүлсэн:

- АТГ-н давуу болон сул тал, түүний үйл ажиллагааны үзүүлэлтийг үнэлэх өргөн хүрээ бүхий чанарын мэдээлэл боловсруулах
- АТГ-н үйл ажиллагааны үзүүлэлт ба хүчин чадлын дутагдалтай талуудыг тодорхойлж, түүнийг засахад шаардлагатай зөвлөмжүүдийг боловсруулах
- Олон улсын түвшинд харьцуулагдахуйц үнэлгээ хийх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Авлигатай тэмцэх байгууллагуудыг бэхжүүлэх төслийн хүрээнд хийгдсэн “Монгол улсын АТГ-ын үнэлгээ” нь Монголын АТГ-ын эрх зүйн орчин, хараат бус байдал, хүний нөөц, санхүүгийн нөөц бололцоо болон үйл ажиллагааны чадавхийн түвшинд Ази Номхон Далайн долоон оронтой харьцуулагдахуйц индикатор болон шалгуураар үнэлгээ хийж Монголын АТГ-ын чадавхи болон үйл ажиллагаанд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлж дүгнэлт гаргах, дүгнэлтэнд үндэслэн сайжруулах санал зөвлөмж боловсруулсан.

Үнэлгээний ажлын хүрээнд баримт бичгийн шинжилгээ, хууль тогтоомж болон мэдээллийн хэрэгсэлд шинжилгээ хийж, төрийн болон төрийн бус байгууллагын олон талт оролцогчидтой ярилцлага хийсэн.

Асуулгын судалгаанд АТГ-ын удирдлагаас 9 хүн, ИНБ-ын удирдлагыг төлөөлж 6 хүн, өдөр тутмын сонины авлигын асуудлаар мэргэшсэн сэтгүүлч 6 хүн, авлигын эсрэг эксперт судлаач 11 хүн нийтдээ 32 хүн оролцжээ.

Мөн ярилцлаганд АТГ-ын удирдлагаас 8 хүн, 4 ажилтан оролцсон. Үнэлгээ нь 2012, 2013, 2014 гэсэн гурван жилийг хамарч байгаа бөгөөд үүнд 2015 оныг хамруулаагүй болно.

Хэрэгцээ шаардлага

АТГ-ын эрх зүйн орчин, хараат бус байдлыг сайжруулах, хүний нөөц, санхүүгийн нөөц болон үйл ажиллагааны чадавхийн үнэлгээ өмнө нь хийгдэж байгаагүй. Үнэлгээний ажлыг Трансперенси Интернэшнл Олон Улсын байгууллагаас боловсруулсан ба Ази номхон далайн бусад 6 оронд уг үнэлгээ нь зэрэг хийгдсэн. Монгол улсын авлигын мэдрэгдэх түвшин харьцангуй өндөр байгаа бөгөөд үүнийг төрөл бүрийн судалгааны үр дүнгээс харж болно. Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын Төсөөллийн Индексээр 175 орноос Монгол улс 100 орноос 39 орноо авч 80 дугаар байранд орсон байна.

Дэлхийн банкны Авлигын хяналтын үзүүлэлт нь 9 өөр төрлийн эх сурвалжийн нийлбэрээр



2015 ОНЫ
10 сараас

2016 ОНЫ
3 сар



32 АСУУМЖ



12 ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

гардаг бөгөөд Монгол улсын хувьд -2,5 –аас 2,5 гэсэн түвшинд байх ёстойгоос -0,5 буюу 40,2 процентиль байна. Олон улсын есөх чадварын тайланд Монгол улс 144 орноос 82-т жагссан үзүүлэлттэй байна.

Арга зүй

Үнэлгээний арга зүйг Трансперенси Интернэшнл Олон Улсын байгууллагаас Ази номхон далайн 7 оронд ашиглагдахуйц байдлаар боловсруулсан. Энэ нь АТГ-ын үйл ажиллагаа болон нэр хүндэд нөлөөлөгч дотоод, гадаад хүчин зүйлийг үнэлэхээр боловсруулагдсан. Энэ цогц үзүүлэлтийн хүрээнд нийт 50 үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.

Мэдээлэл цуглуулалтын онцлог

Мэдээлэл цуглуулалт 2015 оны 11 дүгээр сараас 2016 оны 1 дүгээр сар хүртэл үргэлжилсэн. Тайлангийн үр дүн болон дүгнэлтийн бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг шалгах үүднээс олон нийтэд танилцуулж, тархахаас өмнө тайлангийн эхний хувилбарыг захиалагчид танилцуулж хянуулсан.

Үнэлгээний үзүүлэлтийг тооцохын тулд үнэлгээний баг АТГ-ын тайлан, төлөвлөгөө, АТГ-ын албан хаагчидтай хийсэн ярилцлага, бусад хэвлэл мэдээлэл, төрийн байгууллага, иргэний нийгмийн холбогдох талуудтай ярилцлага хийж шаардлагатай мэдээллийн эх сурвалж дээр үндэслэн үнэлгээг тооцсон.



СӨНСГӨЛГҮЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА



Захиалагч: Финляндын ФЛОМ байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар
Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх юм. Дараах зорилтуудын хүрээнд шинжилгээ хийсэн:

1. Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой статистик мэдээллийг нэгтгэх
2. Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох
3. Сонсголгүй иргэдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг тодорхойлох
4. Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой амжилттай туршлагуудыг тодорхойлох
5. Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал зөвлөмж боловсруулах.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүргийн төлөөллийг хамрууллаа.
Оролцогч талууд:

- сонсголгүй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан дүүргийн мэргэжилтнүүд
- сонсголын бэрхшээлтэй болон бэрхшээлгүй иргэдэд ажил олгож буй хувийн компаниуд, шашны байгууллагууд
- сонсголын бэрхшээлтэй залуучуудыг сургаж буй МСҮТ-үүд

Дээрх оролцогч талууд нь сонсголгүй иргэдэд чиглэн явуулж буй үйл ажиллагаа, үүнд тулгарч буй бэрхшээл, сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломж, нөөцийн талаарх мэдээлэл өгсөн.



2015 ОНЫ
11 сараас

2016 ОНЫ
2 сар



100 АСУУМЖ



39 ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Хэрэгцээ шаардлага

Финляндын ФЛОМ байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг. Иймд сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох судалгаачухал шаардлагатай.

Арга зүй


Энэхүү судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан цуглуулсан. Сонсголгүй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн удирдлагуудаас гүнзгийрүүлсэн ярилцлагын аргаар, сонсголгүй иргэдээс хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан. Мөн баримт бичгийн судалгааны аргыг ашиглан холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны хэрэглэгдэхүүнийг IRIM судалгааны хүрээлэн бэлтгэн боловсруулж, Сонсголгүй иргэдийн мэдээллийн төв (СИМТ)-ийн судалгааны багтай хамтран судалгааг хэрэгжүүлсэн.

Нийт 100 сонсголгүй иргэд, сонсголгүй болон сонсголтой иргэдийг ажиллуулж буй 60 ажил олгогч компаниас дохионы хэл ашиглан асуулга судалгааг авсан.. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 39 байгууллагын удирдлагаас гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн.

Үр дүн


Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт бүртгэлтэй сонсголгүй иргэд нийт 2284 байгааг дүүргээр харьцуулан харуулбал дараах байдалтай байна.



- Нийслэлийн хэмжээнд бүртгэлтэй сонсголгүй иргэдийн дунджаар 19 орчим хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бол 60 орчим хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Сонсголгүй иргэдийн ажил эрхлэлт наснаас нь төдийлөн хамааралгүй байна.
- Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн удирдлагын 41 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль эрх зүйн ямар ч ойлголтгүй байна.
- Хөдөлмөрийн тухайн хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа 4 ба түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэсэн заалтыг тусгасан байдаг. Судалгаанд хамрагдсан 60 ажил олгогчийн жишээг авч үзэхэд, эдгээр байгууллага нийт 14031 ажилтантай ба үүнээс 572 нь буюу 4 хувь орчим нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтантай, хуулийн заалтыг мөрдөж байна.
- Судалгаанд 100 сонсголгүй иргэний 10 нь оюутан, 90 нь хөдөлмөрийн насны иргэн байсан.
- Сонсголгүй иргэдийн 44 хувь нь үйлдвэр, 32 хувь нь худалдааны салбарт ажил эрхэлж байсан.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дүрс. Сонсголгүй иргэдийн голчлон хөдөлмөр эрхэлдэг салбар



- Ажил эрхэлж буй сонсголгүй иргэдийн 71 хувь нь хөдөлмөрийн гэрээ байгуулсан
- 84 хувь нь байнгын, 16 хувь нь цагийн түр ажил эрхэлдэг
- Ажил эрхлээгүй сонсголгүй иргэдийн хувьд тохиромжтой ажлын байр олддоггүй, хэлмэрч байхгүй учир ажил хайх боломжгүй, үр чадвар мэдлэг дутмаг гэх зэрэг шалтгаанаар ажил эрхлээгүй байна



- Судалгаанд оролцсон ажилтай иргэдээс байгууллагын зүгээс хүсч буй дэмжлэгийг нэрлүүлэхэд:
 - а) Сургалт зохион байгуулах /35,3 хувь/
 - б) Ажиллах орчинг сайжруулах /23,5 хувь/
 - в) Ажлын байран дээр ажиллах дохионы хэлмэрчтэй байх /11,8 хувь/
 - д) Эрх ашгийг нь хүндэтгэх /11,8 хувь/
 - е) Эмнэлгийн үзлэг хийлгэх /11,8 хувь/
 - ф) Цалин нэмэгдүүлэх /5,9 хувь/ гэсэн хариултууд өгчээ.

Санал зөвлөмж

Сонсголгүй иргэдийн хувьд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн хууль эрх зүй, бодлого хөтөлбөрийн талаарх ойлголт, мэдээлэл дутмаг байна
2. Хөдөлмөр эрхлэхэд тулгардаг бэрхшээлүүдээр харилцааны бэрхшээл, цалин хөлсний бага байдал, хамт олны хандлага гэсэн асуудлуудыг дурдаж байна

Ажил олгогч байгууллагын хувьд:

1. Тухайн байгууллагад ажил эрхэлж буй сонсголгүй иргэдэдээ хөдөлмөрлөх ээлтэй орчинг бүрдүүлж чадахгүй байна.
2. Хуулиа сахих, нийгмийн хариуцлагаа биелүүлэх тал дээр ажил олгогч байгууллагууд дутагдалтай ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын хувьд:

1. Хөдөлмөр эрхлэлтэнд зуучлах, хөдөлмөр эрхлэх талаарх чадваржуулах сургалтанд хамруулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг гүйцэтгэж байгаа ч тухайн дэмжлэгүүдийн чанарт бус тоон үзүүлэлтэнд анхаарал хандуулж байна.

Төрийн бус байгууллагын хувьд:

1. Сонсголгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-үүд багагүй байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-үүд ажилд, үр чадвар олгох сургалтанд зуучлах үүрэг гүйцэтгэхийн хажуугаар өөрсдөө сонсголгүй иргэдийг авч ажиллуулах, сургах үйл ажиллагааг явуулж байна.

МСҮТ, сургалтын байгууллагуудын хувьд:

1. МСҮТ-үүдэд суралцах сонсголгүй иргэдийн тоо маш бага хувьтай байна. Иймд сургуулиудын зүгээс ч тусгайлсан тоног төхөөрөмж, сургагч багшаар хангах сонирхол багатай байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтанд хамруулснаар тухайн сургалтын байгууллагад ирэх урамшууллын тогтолцоо сул, мэдээлэл дутмаг байна.

“МОНГОЛ ДАХЬ АШИГТ МАЛТМАЛЫН ЛИЦЕНЗИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛД ХИЙСЭН БӨДЛӨГЫН СУДАЛГАА”



Захиалагч: Байгалийн баялагын засаглалын хүрээлэн

Судалгааны зорилго:

Судалгааны зорилго нь судалгааны үр дүн дээр тулгуурлан санал зөвлөмж, бодлогын хураангуй боловсруулах явдал юм. Мөн Монгол улсад ашигт малтмалын лицензтэй олголттой холбоотой мэдээллийг ил болгодог эх сурвалжуудын ил тод байдлыг сайжруулах, түүнд дүн шинжилгээ хийх юм. Үүнд:

- Ашигт малтмалын ерөнхий газрын албан ёсны цахим хуудас(<http://www.cmcs.mgam.gov.mn>),
- Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам (www.eic.mn),
- Олдворлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Ажлын Хэсэг (ОУИТБС) (<http://e-reporting.eitimon-golia.mn>),
- Ялангуяа эдгээр цахим хуудсууд дээр тавигдаж байгаа ашигт малтмалын лицензтэй холбоотой мэдээлэл хоорондын уялдаа холбоог судлах явдал юм.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Уул уурхайн лицензтэй холбоотой мэдээллийн үндсэн эх сурвалж гэдэг утгаараа, Ашигт малтмалын ерөнхий газар манай судалгааны гол бай байсан. Манай судалгаа ашигт малтмалын лиценз олголтын өнөөгийн нөхцөл байдлыг Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын стандартууд, зарчмууд болон цахим засаглалын зарчмуудтай харьцуулсан. Ашигт малтмалын ерөнхий газрын албан ёсны цахим хуудас <http://www.cmcs.mrgam.gov.mn>, Монгол дахь Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлагын Албан ёсны цахим хуудас <http://e-reporting.eitimongolia.mn>, болон Байгаль Орчин Ногоон хөгжил Аялал Жуулчлалын Яамны цахим хуудас <http://www.eic.mn> –ууд дээр тавигдсан ашигт малтмалын лиценз олголттой холбоотой мэдээлэл хоорондын уялдаа холбоог судалсан.

Хэрэгцээ шаардлага

Ашигт малтмалын лицензтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох нь Монгол улсын иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үндэсний баялагыг зөв зохистой хуваарилах тогтолцоог бий болгоход чухал нөлөөтэй. Түүнчлэн Монгол улсад сайн

засаглалыг бэхжүүлэх, оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэхэд маш чухал ач холбогдолтой. Судалгааны үр дүнд тулгуурлан зөвлөмж боловсруулснаар Монгол улсын засгийн газар улсын байгалийн баялагаас бүх нийт ашиг тусыг хүртэж болох тогтолцоог бий болгоно. Ийм тогтолцоог бий болгоход лиценз олголтын ил тод тогтолцоо болон бүх оролцогч талуудад тэнцвэртэй мэдээллийг өгөх нь чухал юм.

Арга зүй

Бид харьцуулалтын аргыг судалгааны үндсэн арга болгосон. Монгол дахь ашигт малтмалын лицензийн нээлттэй өгөгдөл дэх ил тод байдлыг Ашигт малтмалын ерөнхий газрын цахим хуудас, Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлага болон Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал жуулчлалын яамны цахим хуудсууд дээр тавигдсан мэдээллүүдэд дүн шинжилгээ хийж хэмжинэ. Дээр дурьдсан стандартууд, зарчмууд болон ашигт малтмалын лиценз олгохтой холбоотой хуулиуд, эрх зүйн баримт бичгүүдэд баримт бичгийн судалгаа хийсэн. Түүнчлэн зорилтот газруудад ажиглалт хийж, холбогдох албан тушаалтнуудтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийж лиценз олгох болон түүнтэй холбоотой мэдээллүүдийг ил тод, нээлттэй болгох талаар тодорхой ойлголтуудыг авсан юм.



2015 ОНЫ
12 сараас

2016 ОНЫ
3 сар



THE
WORLD
BANK

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

“ОРОН НУТАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЗАГВАР ГЭРЭЭ” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Захиалагч: Дэлхийн банк

Хамтрагч: GIZ, Уул уурхайн яам

Хэлэлцүүлгийн зорилго, зорилт

Хэлэлцүүлгийн гол зорилго нь Уул уурхайн яам, Уул уурхайн компанд, Иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын донор байгууллага, төслүүд зэрэг олон талт оролцогчдын гэрээг сайжруулах талаарх саналыг нэгтгэх явдал байсан. IRIM судалгааны хүрээлэнгийн баг дараах үүрэг гүйцэтгэсэн. Үүнд:

- Бүтэн өдрийн хэлэлцүүлгийн дизайныг гаргаж, дагалдах хөтөлбөр, арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан.
- Хэлэлцүүлгийн бүхий л үйл явцыг гараар болон аудио дуу хураагуураар тэмдэглэж, оролцогчдоос гарсан санал нэг бүрийг баримтжуулан захиалагчид хүлээлгэн өгсөн.
- Хэлэлцүүлгийн үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарласан тайлан болон цаашид “Хамтран ажиллах загвар гэрээ”-г Монгол улсад амжилттай нэвтэрч, нутагшихад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ, үйл ажиллагааны зөвлөмжийг боловсруулж захиалагчид хүргүүлсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

ИРИМ судалгааны хүрээлэн нь модератор, чиглүүлэгчид, зохицуулагч, тэмдэглэл хөтлөгч нар зэрэг нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн оролцогчдын хувьд төрийн байгууллагууд, уул уурхайн компани, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл буюу уул уурхайтай холбоотой салбар бүрийг төлөөлсөн нийт 65 оролцогчдыг хамруулсан.

Хэрэгцээ шаардлага

Дэлхийн банк байгууллага нь Монгол улсын уул уурхайн салбарт уул уурхайн компанийн орон нутагтай хамтран ажиллах харилцааг зохицуулах “Хамтран ажиллах загвар гэрээ”-г нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд, Hogan Lovells хуулийн фирм гэрээний эхний хувилбарыг 2015 оны 10 сард боловсруулж дууссан ба гэрээг бодит амьдралд нийцүүлэн, олон талын ашиг сонирхлыг тэнцвэртэйгээр тусгаж эцэслэхэд талуудыг хамарсан өргөн хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт зайлшгүй болсон юм. Энэхүү өндөр зохион байгуулалт шаардсан амаргүй ажлыг гүйцэтгэхэд Дэлхийн банк ИРИМ судалгааны хүрээлэнг зөвлөхөөр авч ажиллуулан нь “Хамтран ажиллах загвар

гэрээний төсөл” сэдэвт Үндэсний хэлэлцүүлгийг 2015 оны 11-р сарын 17-ны өдөр хамтран зохион байгууллаа.

Арга зүй

Хэлэлцүүлэг нь 2015 оны 11-р сарын 17-ны 09-17 цагийн хооронд бүтэн өдөр хөтөлбөрийн дагуу дараах үндсэн дөрвөн үе шаттайгаар зохион байгуулагдсан.

- Гэрээний талаарх танилцуулга
- Асуулт хариултын хэсэг
- Бүлгийн ажил
- Нээлттэй хэлэлцүүлэг/ Саналын хайрцаг

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Хамтран ажиллах загвар гэрээ хэлэлцүүлгээр гэрээний 6 бүлгийн хүрээнд 65 оролцогчдоос нийт 368 саналыг хүлээн авсан. Талуудын эрх, үүрэг болон Маргааныг Шийдвэрлэх бүлгүүд хамгийн олон тооны саналыг цуглуулсан. Оролцогчдоос ирсэн гол саналуудыг нэгтгэн дүгнэвэл:

- Ихэнх оролцогчид Хамтран ажиллах загвар гэрээний талаар хангалттай ойлголт, мэдлэг байхгүй байсан. Зарим оролцогчид тус хэлэлцүүлгийн үеэр анх удаагаа танилцаж байсан.



2015 ОНЫ
11 сараас

2016 ОНЫ
12 сар



65 ОРОЛЦОГЧ

ҮНДСЭН ХУРААНГУЙ

- Хамгийн шүүмжлэлтэй санал нь Хамтран ажиллах загвар гэрээний үүрэг нь одоо ашиглагдаж байгаа хууль, дүрэм журмуудтай ялангуяа Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай давхардаж байна гэж үзсэн. Тийм учраас ихэнх саналууд нь Монголын одоогийн нөхцөл байдлын талаар судалгаа хийсэн эсэхтэй холбогдож байсан.
- Гэрээ нь орон нутгийн ИТХ зэрэг орон нутгийн төлөөллийг хамруулах шаардлагатай. Суурь асуултууд болох хэн нь түлхүүр оролцогч талууд болох мөн тэдгээр нь яаж Хамтран ажиллах загвар гэрээтэй холбогдож байгаа зэрэг нь нарийн тодорхой биш байна гэж үзсэн.
- Ихэнх хэлэлцүүлгийн оролцогчид Хамтран ажиллах загвар гэрээний бүлэг тус бүрийг тодорхой салбарын ялангуяа уул уурхайн салбарын экспертүүдтэй уулзаж зөвлөлдөх хэрэгтэй гэж үзсэн.
- Аймаг болон суманд Хамтран ажиллах загвар гэрээтэй холбоотой хэлэлцүүлгүүдийг цаашид зохион байгуулж санал авах хэрэгтэй гэж ихэнх оролцогчид үзсэн. Үүнээс гадна хэлэлцүүлгийн оролцогчид Хамтран ажиллах загвар гэрээний эцэслэгдэх явцын талаар мэдээлэл авах өндөр сонирхолтой байсан. Тиймээс Хамтран ажиллах загвар гэрээний сайжруулсан хувилбарыг боловсруулж Засгийн газарт хүлээлгэн өгөхөөс өмнө холбогдох оролцогч талуудад танилцуулах шаардлагатай гэж үзсэн.

“МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ” (SESMIM) ТӨСЛИЙН ЭХЛЭЛТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИӨН БАЙГУУЛАХ ТӨСӨЛ



Захиалагч: АгриТийм Канада Консалтинг фирм

Хэлэлцүүлгийн зорилго, зорилт

Энэхүү хэлэлцүүлгийн гол зорилго нь:

1. Монголын олборлох салбарын өнгөрсөн болон ирээдүйн таван жилийн эерэг өөрчлөлт, хүлээлт,
2. Олборлох салбарын үндэсний хэмжээний бодлого, тэргүүлэх чиглэл ба хэрэгжилтэд тулгарч буй сорилтууд,
3. Олборлох салбарын SWOT анализ,
4. Салбарын гол яамдын харилцаа хамтын ажиллагаа,
5. Монголын олборлох салбарын асуудлын модны шинжилгээ,
6. Чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг оролцогчид хамтран тодорхойлж гаргах байсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Хэлэлцүүлэг Улаанбаатар хотод Чингис зочид буудалд 2016 оны 1 дүгээр сарын 14 болон 15-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Хэлэлцүүлэгт Уул уурхайн яам, БОНХАЖЯам болон Сангийн яамнаас дарга, мэргэжилтэнээс бүрдсэн нийт 48 албан тушаалтан оролцсон. Түүнчлэн SE-SMIM төслийн Монгол, Канад зөвлөхийн баг, Канадын Алберта мужийн удирдлага, Албертагийн Их Сургууль, Калгарын Их Сургуулиас төлөөлөл оролцсон.

Хэрэгцээ шаардлага

Монгол улсын олборлох салбарт Канад улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол улсын олборлох салбарын менежментийг сайжруулах” төсөл 2015-2020 онд хэрэгжиж байна. Төслийн үндсэн зорилго нь олборлох салбарын одоо байгаа бодлого, хууль журмыг хэрэгжилт, олборлох салбарт голлон оролцдог 3 яамны хоорондын ажлын уялдаа холбоо, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулах замаар олборлох салбар дахь төрийн байгууллагын засаглалыг бэхжүүлэх зорилготой.

Уг төслийн эхлэлтийн шатанд төслийг хэрэгжүүлэгч АгриТийм Канада Консалтинг фирм төслийн гарааны нөхцөл байдал,

хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилготой хэлэлцүүлэг зохион байгуулахад IRIM Судалгааны хүрээлэнг зөвлөхөөр авч ажиллуулсан.

Арга зүй

Хэлэлцүүлгийн дизайн нь бүхэлдээ оролцооны аргад суурилсан багийн ажлаар явагдсан. Хэлэлцүүлгийн 2 өдрийн туршид оролцогчид 10 төрлийн багийн ажлыг гүйцэтгэсэн. Ингэхдээ яамдаар болон салбарын гол 5 сэдвээр хуваагдаж байсан.

Яамдаар:

1. Уул уурхайн яам
2. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
3. Сангийн яам

Сэдвээр:

1. Стратеги төлөвлөлт (Орлогын менежмент болон Ирээдүйн баялгийн сангийн менежмент)
2. Лиценз
3. Уурхайн хаалт
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (Байгаль орчны аудит)
5. Кадастр



2016 ОНЫ
1 сараас

2016 ОНЫ
2 сар



48 ОРОЛЦОГЧ

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аргууд:

Оролцогчдыг өөр хооронд нь үр дүнтэй хамтран ажиллаж, гүнзгий мэдээлэл гарган авахын тулд дараах оролцооны аргуудыг ашигласан.

1. Өнгөрсөн болон ирээдүйн сайн өөрчлөлт, хүлээлтийн зураглал
1. SWOT шинжилгээ
2. Асуудлын модны шинжилгээ
3. Ирээдүйд гарах үр дүнгийн зураглал
4. Чадавхийг бэхжүүлэх төлөвлөлт
5. Оролцогч талуудын аалзны торон үнэлгээ
6. Яамд хоорондын уялдаа, хамтын ажиллагааны Н форм үнэлгээ
7. Эхний жилийн төлөвлөгөө –Дэлхийн кафе арга

Хэлэлцүүлгийн төгсгөлд оролцогчдын дунд хэлэлцүүлгийн үр дүнг үнэлэх үнэлгээний хуудас аялуулсан. Нийт 26 оролцогч үнэлгээ өгсөн ба үнэлгээний дундаж нь 5 онооноос 4.7 буюу эерэгээр үнэлсэн.

Гүйцэтгэсэн үүрэг:

IRIM Судалгааны хүрээлэнгийн баг дараах үүрэг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Хоёр өдрийн хэлэлцүүлгийн дизайныг гаргаж, дагалдах хөтөлбөр, арга зүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулж, 14 хүний бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулалтанд ажилласан.
2. Хэлэлцүүлгийн бүхий л үйл явцыг гараар болон аудио дуу хураагуураар тэмдэглэж, оролцогчдоос гарсан санал нэг бүрийг баримтжуулан захиалагчид хүлээлгэн өгсөн.
3. Хэлэлцүүлгийн үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарласан тайлан болон цаашид төсөлд шаардлагатай арга хэмжээ, үйл ажиллагааны зөвлөмжийг боловсруулж захиалагчид хүргүүлсэн.

ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮД

- “Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь” зөвлөх үйлчилгээ **83**
- Олборлох салбарын авилгын эрсдлийн үнэлгээ **86**
- Орон нутагт тогтвортой хөгжлийн боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын суурь судалгаа **89**
- НҮБХХ- Тогтвортой хөгжлийн зорилтууд дахь жендэрийн үзүүлэлтүүдийн үндэсний үнэлгээ **92**
- Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх хөтөлбөрийн суурь судалгаа **94**
- Бүс нутгийн эдийн засгийн интеграцичлал: Монгол дахь эрсдэл ба боломж **97**
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эхрлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ өгөх, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах **99**



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ “ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ” ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



Захиалагч: Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Азийн Хөгжлийн Банк

Хамтрай ажиллагч байгууллага

- Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам (БСШУЯ)
- Төсөл Хэрэгжүүлэх Нэгж (ТХН)
- Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газар
- Дээд боловсролын сургалтын байгууллагууд

Тослийн зорилго

- Их дээд сургуулиудад Төгсөгчдийг Мөшгөх Судалгаа (ТМС), Хөдөлмөрийн Зах Зээлийн (ХЗЗС) болон Ажил Олгогчдын Сэтгэл Ханамжийн Судалгааг (АОСХС) жил тутам төлөвлөх, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, шаардлагатай тайланг бэлтгэхэд нь техникийн туслалцаа үзүүлэх
- Эдгээр судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх, оюутнуудад ажил мэргэжлийн зөвлөгөө, мэдээллийг хүргэх, сургууль ба үйлдвэрлэлийн салбарын түншлэлийг хөгжүүлэх гарын авлага бэлтгэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хэрэгцээ шаардлага

Монгол улсад 2012-2013 оны хичээлийн жилд 99 дээд боловсролын байгууллагад 170 мянган оюутан суралцаж байжээ. Хэдийгээр хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй, өндөр чадвартай ажилтны эрэлт хэрэгцээ байгаа боловч, дээд боловсролын салбар оюутнуудад ажил эрхлэх боломжтой үр чадвар эзэмшүүлдэггүй, зардал багатай, чанар муутай хөтөлбөрөөр оюутан бэлтгэдэг, төгсөгчдийн дунд ажилгүйдэл ихтэй гэсэн шүүмж их гардаг.

Эдгээр асуудал нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөхөд ашиглаж болох хөдөлмөрийн зах зээл, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа, мэдээлэл дутагдалтай байгаатай холбоотой. Ийм судалгаа, мэдээллийн хэрэгцээ байгааг зарим их сургууль сайтар мэдэрч, өөрсдийн нөөцөөр, өөрсдийн боловсруулсан аргазүйгээр зарим судалгааг хийж байна. Гэхдээ дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах ажлыг эрчимжүүлэх, оюутнуудын ажил эрхлэх чадварыг дээшлүүлэхийн тулд судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнийг цаашид сайжруулах шаардлагатай.

Хамрах хүрээ

Монголын их, дээд сургуулиуд, БСШУЯ, Боловсролын хүрээлэн.

Үйл ажиллагаа

- Хөтөлбөрийн шинэчлэл, Ажил мэргэжлийн зөвлөгөө, Аж-үйлдвэрийн түншлэлийн гарын авлагуудыг боловсруулсан
- Эдгээр гарын авлагуудын зорилго, бүтэцийн талаар хот, хөдөөгийн 60 орчим томоохон их, дээд сургуулиудын 300 гаруй мэргэжилтнүүдэд танилцуулга, сургалт хийсэн
- ХЯ-наас жил бүр хэрэгжүүлдэг “Барометрийн судалгаа”-ны асуулгын үр дүнг их, дээд сургуулиуд ажил олгогчийн сэтгэл ханамжийн талаарх судалгаандаа ашиглаж байх бас нэгэн эх сурвалжтай болох боломжтой болгох зөвшөөрлийг судлаж байна
- Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнийг ҮСХ-оор батлуулах ажил хийгдэж байна
- Боловсролын сабарын журмуудад санал зөвлөмж боловсруулан бэлтгэх ажил хийгдэж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь:

1. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, төгсөгчдийг мөшгөх судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулсан
2. Өгөгдөл цуглуулалт, оруулалт, дүн шинжилгээ хийх, тайлан бичих гарын авлага боловсруулсан



2015 ОНЫ
1 сараас

2016 ОНЫ
4 сар

ТӨСЛИЙН ХУРААНГУЙ

3. Эдгээр судалгааны аргачлалын талаар хот, хөдөө орон нутгийн 60 орчим томоохон их, дээд сургуулиудад танилцуулга, сургалт хийсэн
4. Төгсөгчдийг мөшгөх туршилт судалгааны хоёр үе шатанд 6 их, дээд сургуулийн 1800 гаруй төгсөгч хамрагдсан. Сургуулиа төгсөөд 1 жил болж буй төгсөгчдийн 70 хувь нь ажил эрхэлж буй бол ажилгүйдэл 9%, дундаж цалин 660 мянган төгрөг байна.
5. Ажил олгогчийн сэтгэл ханамжийн туршилт судалгаанд 200 ажил олгогчоос утсаар, 1700 ажил олгогчоос анкетаар, 33 ажил олгогчоос гүнзгийрүүлсэн ярилцлагаар мэдээлэл цуглуулсан. Төгсөгчдийн ихэнх ур чадваруудад ажил олгогчид дундаж ба дунджаас дээш сэтгэл ханамжтай байна.
6. Хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий судалгаагаар, дээд боловсролын өгөөж 40, дээд боловсролтой хүмүүс улсын дунджаас ажилгүйдэл багатай (6.5%), шилжилт хөдөлгөөн илүү хийх хандлагатай байна.



ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ АВЛИГЫН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ СУДАЛГАА




Захиалагч: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь олборлох салбарын үе шатуудын шийдвэр гаргалтын түвшин бүр дэх авлигын эрсдлийг тодорхойлж, нарийвчилсан үнэлгээ хийх явдал юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад илрүүлсэн авлигын эрсдэл дээр үндэслэн, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулах бөгөөд улмаар уул уурхайн олборлох салбар дахь авлигын эрсдэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний суурь нөхцөл байдлыг тодорхойлоход ашиглана.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Энэхүү судалгааг Сэлэнгэ, Өмнөговь болон Улаанбаатар хотод гүйцэтгэсэн. Судалгааны бэлтгэл шатанд, судалгааны баг уул уурхайн салбарын үйү ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулж буй оролцогч талуудыг нарийвчлан тодорхойлсон. Судалгаанд орон нутгийн болон үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын шийдвэр гаргагчид, уул уурхайн компаниуд болон төрийн бус байгууллагуудыг хамруулсан.



2015 ОНЫ
11 сараас

2016 ОНЫ
4 сар

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Монгол улс 2006 онд ‘Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга’-д нэгдэн, Ашигт Малтмалын Тухай хуульд (48.10) нэмэлт өөрчлөлт оруулан ашиглалтын зөвшөөрөл эзэмшигчдийг улсад болон орон нутгийн төсөвт оруулсан татвар, төлбөрийг ил тод мэдээлэх үүргийг тусгаж оруулсан. ОСИТБС нь уул уурхайн компаниуд болон төрийн байгууллагуудаас хүлэн авсан төлбөр, тооцоог тогтмол мэдээллэдэг. 2006 оны 10-р сард, ‘Төлсөнөө нийгэл’ төрийн бус байгууллага үүсгэн байгуулагдсан бөгөөд, уул уурхайн салбарт ил тод байдал бий болгохоор ажиллаж байна. 2015 онд Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр, орон нутгийн засаг захиргаа олборлох салбарын орлогоос тодорхой хувийг авах эрхтэй болсон нь орон нутгийн удирдлагын зөвшөөрөл олгох олборлох салбараас оруулж буй орлогын зохицуулалтыг ил тод, нээлттэй мэдээлэх үүрэг хариуцлагыг нь улам нэмэгдүүлсэн юм. Энэхүү судалгаа нь олборлох салбарын ил тод байдлыг сайжруулахад чиглэн үйл ажиллагаа явуулж буй АТГ, иргэний нийгмийн байгууллагуудын болон эвслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц ажил болж байна.

Арга зүй

Уул уурхайн олборлох салбар дахь авлигын эрсдэлийг тодорхойлохдоо НҮБХХ-өөс боловсруулсан ‘Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах’ гарын авлагад өгөгдсөн арга зүйг Монголын нөхцөл байдалд тааруулан нутагшуулж, ашигласан. Энэхүү судалгааны хүрээнд уг гарын авлагад өгөгдсөн 5 үе шатаас, зарлагын менежмент буюу сүүлийн хэсгийг хасч олборлох салбарын 4 гол үе шатанд авлигын эрсдэлийн үнэлгээг хийсэн. Авлигад өртөх эрсдэл бүхий дараах 4 үе шатад авлигыг эрсдэлийн үнэлгээ хийсэн.

1. Бодлого, институт хууль, эрх зүйн хүрээ боловсруулах
2. Гэрээний хэлцэл хийх
3. Олборлох үйл ажиллагаа, дагаж мөрдөх зохицуулалт
4. Орлогын зарцуулалт ба төсвийн зохицуулалт

‘Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах’ гарын авлагад заасанчлан, судалгааны мэдээллийг ганцаарчилсан ярилцлага болон баримт бичгийн судалгааны аргаар цуглуулсан.

Ганцаарчилсан ярилцлагыг хийхдээ, авлигын байж болох эрсдэлийн талаарх мэдлэгтэй оролцогч талуудаас түүвэрлэсэн бөгөөд, тэдгээрийн авлигын үр нөлөө, эрсдэлийн үнэлгээ, авлигын эрсдэлийг бууруулах одоогийн болон төлөвлөж буй хяналтуудын үр нөлөө, нийгэмд үзүүлэх ашиг тус гэх мэт уг гарын авлагад заасан ярилцлагын удирдамжийг мөрдлөг болгосон.

Судалгааны баг нь Монгол дах олборлох салбарын үйл ажиллагаа, холбогдох хууль эрх зүйн орчинтой холбоотой баримт бичгүүд, олборлох салбарын гадаад болон дотоод зохицуулалт, дүрэмж журмуудыг судалсан.

Цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн, дараах үндсэн алхмуудаар эрсдэлийн үнэлгээг хийнэ.

1. Авлигын эрсдэлийг тодорхойлох
2. Магадлалыг үнэлэх
3. Авлигын үр нөлөөг үнэлэх
4. Авлигын эрсдэлийн түвшинг тооцох

Авлигын эрсдэлийг үнэлэх аргачлал, шкал болон томъёог ‘Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах’ гарын авлагад заасан байгаа.

‘Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах’ гарын авлагад заасанчлан, эрсдэлийн магадлалын үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ болон авлигын эрсдэлийн түвшинг тусгасан Эрсдэлийн Шинжилгээний Тайланг боловсруулна.

ОРОН НУТАГТ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НОГООН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН СУУРЬ СУДАЛГАА




Захиалагч: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
'Тогтвортой Хөгжлийн Боловсрол' төсөл

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү суурь судалгаа нь

- Орон нутгийн тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагуудын мэдлэг олгох үйл ажиллагааг явуулахад тулгарч буй бэрхшээл, эрсдэл, боломж, байгууллагуудын чадавхи, нөөц болон өрсөлдөх чадварыг тодорхойлох;
- Судалгааны үр дүн дээр суурилж, орон нутагт ногоон хөгжил болон тогтвортой хөгжлийн боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудыг чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах; гэсэн үндсэн 2 зорилготой

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Дархан, Ховд, Сэлэнгэ, Өвөрхангай, Сүхбаатар гэсэн 5 аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулна. Судалгаанд эцэг эхчүүд, сурагчид, сургуулиуд болон тогтвортой хөгжил(ТХ) ба ногоон хөгжлийн(НХ) чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд, институтуудыг хамруулсан.



2015 ОНЫ
12 сараас

2016 ОНЫ
3 сар

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

ТХБ төслийн ерөнхий зорилго нь 'Тогтвортой хөгжлийн боловсролыг Монгол улсын ЕБС-ийн системд нэвтрүүлж, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн таатай (инстиутуцийн, эрх зүйн, зохион байгуулалтын) орчинг бүрдүүлнэ. Ялангуяа энэхүү судалгааны ажил нь ТХБ төслийн хоёр дах бүрэлдэхүүн хэсэг болох:

'Олон нийт болон шийдвэр гаргагч нарт тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн тухай мэдээлэл, мэдлэг, үзэл санааг хүргэж, төсөлд хамрагдсан аж ахуй нэгж, компани, байгууллагуудад байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ISO: 14001 баталгаажуулалт хийлгэнэ' гэсэн бүрэлдэхүүн хэсэгт хувь нэмэр оруулах ажил болно.

Дээрх бүрэлдэхүүн хэсгийн 2015 оны төлөвлөгөөний хүрээнд, олон нийтийн дунд сургалт зохион байгуулах, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн суурь судалгааг явуулах ажлууд тусгагдсан байгаа. Судалгааны үр дүн дээр суурилж, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн чиглэлээр олон нийтийн дунд явуулах үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажил амжилттай дуусах юм.

Суурь судалгаа нь дараах хоёр үндсэн үйл ажиллагаанд ихээхэн үр ашигтай ажил болж байна:

- Орон нутгийн боловсролын байгууллагын ТХ ба НХ-н талаарх ойлголтыг бэрхжүүлсэнээр эдгээр байгууллага нь орон нутгийн иргэдэд мэдлэг түгээх сургалт явуулах үндсэн байгууллагууд болох бөгөөд орон нутгийн удирдлагыг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, амьдралын хэв маяг, соёлыг дэмжихэд нөлөөлөл үзүүлнэ.

- БСШУЯ-аас орон нутгийн боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Энэ төлөвлөгөө нь олон улсын хөгжлийн байгууллагын төлөвлөгөөнд үйл ажиллагаануудыг багтаах, санхүүгийн дэмжлэг авч, хамтран хэрэгжүүлэх боломжийг олгох юм.

Арга зүй

Суурь судалгааны мэдээллийг асуумж, ажиглалт гэх мэт тоон судалгааны арга болон ярилцлага, баримт бичгийн судалгаа гэх мэт чанарын судалгааны аргыг ашиглан цуглуулсан.

Оролцогч талуудтай хийсэн ярилцлага нь ТХ, НХ-ийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааны давуу тал, сул тал, боломж, аюул болон ТХ ба НХ сургалтын үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл, эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн. Ярилцлагын үр дүнг нь баримт бичгийн судалгаанаас олж авсан мэдээллээр баяжуулна.

Асуумж нь багш болон сурагчдад зориулагдсан бөгөөд, тэдгээрийн ТХ ба НХ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлоход ашигласан.

“ТОГВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ЖЕНДЕРИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН СУУРЬ ҮНЭЛГЭЭ”



Захиалагч: НҮБ-н Хөгжлийн Хөтөлбөр Монгол дахь төлөөлөгч
Судалгааны зорилго, зорилт

- Судалгааны үндсэн зорилго нь Тогтвортой Хөгжлийн(ТХ) зорилго 5-г түшиглэн ТХ-н зорилго 1, ТХ-н зорилго 8, ТХ-н зорилго 10, ТХ-н зорилго 11, ТХ-н зорилго 13 болон ТХ-н зорилго 16-н индикаторуудын тоон мэдээлэл хүйсээр задарсан байгаа эсэхийг судалж жендерийн шинжилгээ хийх явдал юм.
- Судалгаагаар ТХ-н зорилтуудын индикаторуудтай холбогдох мэдээллийн эх сурвалжийг тогтоон, Монгол улсад ТХ-н зорилтуудын индикаторуудын мэдээллийг цуглуулах, одоо байхгүй байгаа мэдээллийг хэрхэн бүрдүүлэх талаар зөвлөмж боловсруулсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Тус судалгааны хүрээнд засгийн газрын тохируулагч, гүйцэтгэгч агентлагууд, яамдууд, олон улсын болон төрийн биш байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан. Ингэхдээ судалгааны хамгийн том мэдээллийн бааз гэдэг утгаар нь Улсын Бүртгэл Статистикийн Ерөнхий Газар болон Жендерийн Үндэсний Хороотой ойр ажилласан.

Хэрэгцээ, шаардлага

НҮБ-н Статистикийн Комиссоос гишүүн орнуудтай зөвшилцсний дүнд Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг багц бичиг баримтыг боловсруулсан. 2015 оны 9-р сард болсон НҮБ-н дээд хэмжээний уулзалтаар Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг(2015 оноос хойших Хөгжлийн Хөтөлбөр) анхны загварыг батлаад, гишүүн улс орнуудаа эдгээр 17 зорилго холбогдох 169 зорилтуудад түшиглэн өөрсдийн орны онцлогт тохирсон зорилтууд, индикаторуудаа боловсруулахыг удирдамж болгосон.

Түүнчлэн НҮБ-н Ажлын Баг “2015 оноос хойших Хөгжлийн Хөтөлбөр”ийн хүрээнд улс орнуудыг, сэдэв бүрээр ТХ-н зорилтуудын индикаторуудын мэдээлэл бүрдэлтэнд дүн шинжилгээ хийж, бүрдээгүй байгаа мэдээллийг тодорхойлох шаардлагатайг онцолсон. Ажлын Баг мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн шинэ эх сурвалжийг шаардаж байгаа гэдгийг тэмдэглэсэн. Жишээлбэл, ТХ-н зорилтуудын индикатортой холбогдох мэдээллийг тухайн улсын статистикийн газарт бүрдсэн “хүн ам, орон сууцны судалгаа” зэрэг эх сурвалжаас авч болж байхад зарим индикаторуудын мэдээллийн хувьд өөр эх сурвалжаас гарч ирж байгааг онцолсон.

Маш олон тохиолдолд ТХ-н зорилтот хэсгүүдийг хамруулахын тулд шинээр индикаторуудыг боловсруулах холбогдох мэдээллийг бүрдүүлэх тогтолцоог бий болгох мөн мэдээллийг цуглуулах түүнд дүн шинжилгээ хийхийн тулд үндэсний статистикийн газарт томоохон хөрөнгө

оруулалт хийх шаардлага гарч ирж байна. “2015 оноос хойших Хөгжлийн Хөтөлбөр” нь мэдээллийг орлогоор, хүйсээр, насаар, арьс өнгөөр, угсаатнаар, шилжилт хөдөлгөөний статусаар, газар зүйн байршлаар болон хөгжлийн бэрхшээлтэй гэх мэтээр задаргаатай гаргаж “хэнийг ч орхигдуулахгүй” гэсэн зарчмыг баримталж байна. Тиймээс ТХ-н зорилго 17, 18 болсон задаргаатай мэдээллийг тогтмол, дэс дараалалтай бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт хийснээр “мэдээллийн хувьсгал”-г хийхэд түлхэц болно.

Арга зүй

- ТХ-н зорилгуудын жендерийн чанарын индикаторууд дээр анхаарлаа хандуулсан.
- Гол оролцогч талуудтай зөвшилцсний дүнд, мэдээллийг хэрэглэгч болон мэдээллийг бүрдүүлж байгаа хоёр өнцгөөс ТХ-н мэдээллийн өнөөгийн түвшинг тодорхойлон дүн шинжилгээ хийсэн. Үр дүнд нь зөвлөх болон захиалагч мэдээллийн хамгийн гол хэрэглэгч хэн болохыг тодорхойлсон.
- ТХ-н ижил төстэй судалгаа, мөн өөр оронд жишиг болгоод хэрэглэж болох дүн шинжилгээний болон арга зүйн загварыг боловсруулсан.

Дээр дурьдсан зорилго, зорилтуудтай холбоотойгоор баримт бичгийн судалгаа хийгдсэн.

Мэдээлэл цуглуулалт

Энэхүү судалгааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан нийт 30 гаруй байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан. Судалгааны онцлогоос шалтгаалан чанарын болон тоон мэдээллийг дараах судалгааны арга зүйг ашиглан цуглуулсан. Үүнд:

- Гүнзгийрүүлсэн ярилцлага
- Хагас бүтэцчилэгдсэн ярилцлага
- Бичиг баримтын судалгаа



2016 оны
1 сараас

2016 оны
4 сар



THE
WORLD
BANK



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

“МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”- ИЙН СУУРЬ СУДАЛГАА




Захиалагч Дэлхийн банк

Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго нь суурь судалгааны хүрээнд нийгмийн хариуцлагын талаар хүмүүсийн мэдлэг, хандлага болон төслийн хэрэгжилтийн дараах нийгмийн хариуцлагын механизмын ил тод байдлын талаарх мэдээллийг цуглуулах юм.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Хамрах хүрээ

“Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх Хөтөлбөр”-ийн суурь судалгаа нь Улаанбаатар хотын 3 дүүрэг, 10 аймгийн төв болон 10 сумдуудад хийгдсэн.



2016 ОНЫ
1 сараас

2016 ОНЫ
4 сар



1067 ӨРХ

90 ИРГЭНИЙ НИЙГМИЙН
БАЙГУУЛЛАГА



30 ИРГЭНИЙ
НИЙГМИЙН
БАЙГУУЛЛАГА

57 ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГА



19 ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГА

10 АКАДЕМИК
БАЙГУУЛЛАГА

10 ИНБ-УУДЫН ДУНД ХОТ БОЛОН ОРОН НУТАГТ 10
УДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙДЛААР СУДАЛГААНЫ
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хэрэгцээ шаардлага

Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь нийгмийн хариуцлагын тусламжтайгаар харьцангуй буурай нутгийн иргэдийн төрийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо, чанартай төрийн үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

“Монгол улсад нийгмийн хариуцлагын бэхжүүлэх” хөтөлбөрийн гол зорилго нь (1) Иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагад хариуцлага тооцох чадавхийг нэмэгдүүлэх, (2) мэдээллийн ил тод байдал болон оролцооны механизмын үр нөлөөтэй, тогтвортой ажиллагааг сайжруулан нийгмийн хариуцлагын институцийг бэхжүүлэх замаар Монгол улсын үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн нөөцийн менежментийг илүү ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй болгон нийгмийн хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.

Нийгмийн хариуцлагын дэмжлэгтэйгээр ядуурал харьцангуй ихтэй орон нутгийн иргэд төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох, чанартай үйлчилгээг хүртэх боломжоор хангагдана.

Арга зүй

Судалгааг чанарын болон тоон олон төрлийн аргуудыг ашиглан явуулсан. Суурь судалгаа нь нийт 7 хэрэглэгдэхүүнээр мэдээлэл цуглуулсан. Өрхийн асуулгын хувьд эхлэлтийн цэгийн аргыг ашигласан 66 асуулт бүхий анкетаар цуглуулсан. ИНБ-ын ярилцлага хэлбэрээр нь түүвэрлэн ярилцлага хийгдсэн.

Түүнчлэн ИНБ-уудын дунд оролцооны тодорхой аргуудад тулгуурласан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА: МОНГОЛ ДАХЬ БОЛОМЖ БА ЭРСДЭЛ



Захиалагч Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг

Судалгааны зорилго, зорилт

Бодлого хэрэгжүүлэгчид, төрийн албан хаагчид, иргэний нийгмийн болон хувийн байгууллагуудын чадварыг хөгжүүлэх мөн төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог дэмжих замаар тэднийг худалдааны бодлогыг хамтран боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжихэд төслийн үндсэн зорилго оршино. Тус төслийн хүрээнд цогц, нарийвчилсан судалгааны ажлыг хийх нэн шаардлага тулгарсан бөгөөд судалгааны гол зорилго нь Монгол улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нэгдэн орох боломж, арга замыг олох мөн Монгол улс бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, түншлэлийн гэрээ хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм. Судалгааны үр дүн нь цаашид Монгол улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд баримтлах стратегийн төлөвлөгөөг боловсруулахад ашиглана.

Зорилт:

- Монгол улс нэгдэж болох бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг тодорхойлох
- Монгол Улс хөрш орнууд болон худалдааны түншүүдтэй хамтран ажиллах боломж ба эрсдэлийг тусгах
- Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо, Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа, Бүсийн цогц Эдийн засгийн түншлэл, Транс-Номхон далайн хамтын ажиллагаанд нэгдэх асуудлыг тусган Монгол улсад хамгийн оновчтой сонголтыг зөвлөх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хүрээ

Судалгааны ажлын хүрээнд судалгааны баг нь одоогийн бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны нөхцөл байдал, холбогдох дүрэм журмыг судалж, судлахаар сонгосон улсуудын тэргүүн туршлагыг судлах замаар Монгол улс хамтын ажиллагаанд нэгдсэнээр үүсч болох эрсдэл бэрхшээлүүдийг тодорхойлно.

Судлах гол асуудлууд:

- Монголын нөхцөлд хамгийн тохиромжтой эдийн засгийн хамтын ажиллагааны механизмыг олох
- Бүрэлдэхүүнд нэгдсэнээр ямар боломж эрсдэл гарах, Монгол улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар урьдчилан харах
- Хөрш болон хамтрагч орнуудын сонирхол нөхцөл байдлыг авч үзэх
- Бусад орны хамтын ажиллагаанд нэгдсэнээр сурсан сургамж туршлагын судлах

Хэрэгцээ шаардлага

Одоогоор бүс нутгийн хамтын ажиллагааны механизмын хүрээнд хийгдсэн судалгаа дутмаг байгаа нь түүнээс Монгол улсын хүртэх боломж бололцоог хааж байна. Тиймээс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нэгдэх хүрээнд хэрэгжүүлсэн

бодлогыг дахин хянаж үнэлэх, түүний хүрээнд цаашид хэрэгжүүлэхэд тохиромжтой арга хэмжээг төлөвлөх, тус хамтын ажиллагаанд нэгдсэнээр гарах үр дүн түүний давуу болон сул талуудыг тооцсон судалгааг хийх нэн шаардлагатай байгаа юм.

Арга зүй

Судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилгын дагуу дараах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөсөн:

- Сонгогдсон 5 орны бүс нутгийн эдийн засгийн интеграцийн тэргүүн туршлагыг судлах кейс шинжилгээ,
- Сонгогдсон бүс нутгийн эдийн засгийн интеграци, хамтын ажиллагааны хэлбэрүүдийн боломж болон эрсдлийн шинжилгээг гадаадын хөрөнгө оруулалт, худалдаа, олон улсын нэмүү өртгийн сүлжээний хүрээнд шинжилнэ,
- Ерөнхий тэнцвэрийн загвар ашиглан эдийн засгийн өгөөжийг үнэлнэ.

Мэдээлэл цуглуулалтын онцлог

Судалгааны мэдээллийг ярилцлагын, баримт бичиг судлалын болон тоон судалгааны аргаар цуглуулах ба судалгааны хүрээнд мөн Монгол улстай улс төр, эдийн засаг, газар зүйн онцлогоороо ижил төстэй орнуудын туршлагыг судална.



2016 ОНЫ
3 сараас

2016 ОНЫ
6 сар

Захиалагч: Хөдөлмөрийн яам

Сүдэлгээн зорилго, төлөвлөгдсөн үйл ажиллагаа

Сүдэлгээн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ өгөх, хэрэгжлийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах үзэгдлийг ажлын үр дүнд тусгаснаар таллан бэлтгэх

Бодлого, хөдөлмөрийн үнэлгээ зорилготой бүлэг, оролцогч талуудад үнэлгээ өгөх, хөдөлмөрийн үнэлгээ зорилготой гаргах, хэрэгжилтэнд үнэлгээ өгөх

Энэхүү зорилгоор харахад үндсэн үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах юм

Сүдэлгээн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ өгөх, хэрэгжлийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах юм




“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ өгөх, хэрэгжлийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулах” үйлчилгээний төсөл

Хөдөлмөрийн яам



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



2016 ОНЫ
3 сараас
2016 ОНЫ
5 сар

Хамрах хүрээ

Улаанбаатар, Баян-Өлгий, Хөвсгөл, Дорнод, Сэлэнгэ аймгуудаас 390 ХБИ-ээс асуумж авч, 110 оролцогч талтай ганцаарчилсан ярилцлага хийж, 15 бүлгийн ярилцлага зохион байгуулна.



390 АСУУМЖ

Хэрэгцээ шаардлага

2006 онд Нэгдсэн үндэсний байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц ” батлагдаж, Монгол улсад 2009 онд тухайн конвенцийг дэмжин нэгдэн орсон. Энэ утгаараа Монгол улсын төр, засгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр нэлээдгүй бодлого хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Эдгээр бодлого, хөтөлбөрийн үр дүнд хэрэгжиж буй үйл ажиллагаануудын ойрын жилүүдэд эрчимжиж төр засгийн зүгээс бодит үр дүн, үр нөлөөг нь хэмжих шаардлага гарч байна.



110 ЯРИЛЦЛАГА



15 ФОКУС
БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА